

## НИЙСЛЭЛИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ГАЗРЫН ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

2020 оны 06 дугаар сарын 20

Улаанбаатар хот

Нийслэлийн улсын бүртгэлийн газар нь Улсын бүртгэлийн ерөнхий газар, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2020 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө болон тус газраас 2020 онд хэрэгжүүлэх гүйцэтгэлийн төлөвлөгөө, дэвшүүлсэн зорилтуудыг хэрэгжүүлэн ажиллаж, хэлтэс, нэгжүүдийн үйл ажиллагааг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, хуульд заасан улсын бүртгэлийн зарим төрлийн үйлчилгээг үзүүлэх гэсэн 2 үндсэн чиг үүргийн хүрээнд Захиргааны хэлтэс /17/, Бүртгэлийн хэлтэс /38/, Харилцагчийн үйлчилгээний хэлтэс /2/, Архивын хэлтэс /10/, Дүүргүүдийн улсын бүртгэлийн хэлтэс /308/ гэсэн нэгжүүдтэйгээр нийт 375 ажилтан, албан хаагчтайгаар үйл ажиллагаагаа хэрэгжүүллээ.

### Нэг. Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, үр дүн

2020 оны эхний хагас жилийн байдлаар Засгийн газрын 2 тогтоолын 12 заалт, нийт 2 шийдвэрийн 12 заалтыг хяналтанд авч хэрэгжүүлэн ажиллалаа. Эдгээрээс тайлант хугацааны зорилтод бүрэн хэрэгжсэн 12 байгаа бөгөөд хэрэгжилт 100%-тай байна.

УИХ-ын тогтоол, Засгийн газрын тогтоол, Засгийн газрын хуралдааны тэмдэглэл, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын тушаалаар төрийн захиргааны байгууллага, агентлагын дарга нарт үүрэг болгосон заалт бүрийг хяналта нд авч, хяналтын хуудас хөтлөн ажиллаж байна. Тогтоол, шийдвэрийн хэрэгжилтэд улирал тутамд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийн, газар хэлтсийн гүйцэтгэлийн төлөвлөгөө, ажлын үр дүнг үнэлэх үзүүлэлт болгон ашиглаж байна.

Холбогдох эрх зүйн актын хэрэгжилтийн байдлыг хариуцан хэрэгжүүлсэн хэлтэс, нэгжийг үзүүлвэл:

№	Хариуцан хэрэгжүүлэх хэлтэс, нэгж	Нийт заалт	Үүнээс						
			100%	70%	30%	Хэрэгжээгүй	Хугацаа болоогүй	Хүчингүй болсон	Биелэлт хувь
1	Захиргааны хэлтэс	10	100					-	100
2	Харилцагчийн үйлчилгээний хэлтэс	1	100					-	100
3	Бүртгэлийн хэлтэс	1	100					-	100
	Нийт	12	100					-	100

Тайлангийн хугацаанд Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн захирамж Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын тушаал, үүрэг, чиглэлүүдийг хяналтад авч хэрэгжүүлэн ажилласан. Тухайлбал:

1. Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2020 оныг “Нэг хот-нэг стандарт” зорилтот жил болгон зарлах тухай захирамж;

**Хэрэгжилт:** Захирамжийн хүрээнд 2020 онд тус газраас хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулан хүргүүлсэн.

2. Монгол Улсын Их Хурлын ээлжит сонгуулийг улсын бүртгэлийн байгууллагын хуулиар хүлээсэн чиг үүргийн дагуу зохион байгуулах буюу сонгогчдын нэрийн жагсаалтыг үнэн зөв үйлдэх, иргэний оршин суугаа газрын хаягийн мэдээллийн санг цэгцлэх талаар Улсын бүртгэлийн ерөнхий газраас ирүүлсэн чиглэл;

**Хэрэгжилт:** Нийслэлийн хэмжээнд нэг хаягт 10 ба түүнээс дээш сонгогч бүртгэгдсэн 51692 иргэн, ижил овог нэртэй 1382 сонгуулийн насны иргэдийн хаягийн зөрчлийг арилгах ажлыг зохион байгуулж, тайлан тоон мэдээг Иргэний улсын бүртгэлийн газарт хүргүүлсэн.

3. Монгол Улсын Их Хурлын 2020 оны ээлжит сонгуулийг зохион байгуулах бэлтгэл ажлын хүрээнд Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль, холбогдох бусад хууль тогтоомжид заасан улсын бүртгэлийн байгууллагын чиг үүргийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах үүрэг бүхий ажлын хэсгийг Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2020 оны А/05 дугаар тушаал;

**Хэрэгжилт:** Дээрх ажлын хэсгийн 2020 оны 01 дүгээр сарын 13-ны өдрийн хурлаар “Монгол Улсын Их Хурлын 2020 оны ээлжит сонгуулийн хуулийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны 60 заалт бүхий төлөвлөө”-ний төслийг танилцуулсан. Уг төлөвлөгөөнд газар, хэлтсүүдээс санал авч нэгтгэн, ажлын хэсэгт хүргүүлсэн. Мөн Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1 дэх хэсэгт иргэний засаг захиргааны нэг нэгжээс нөгөөд шилжих шилжилт хөдөлгөөний бүртгэлийг ээлжит сонгуулийн жилийн 02 дугаар сарын 01-ний өдрөөс түр зогсоохоор зохицуулсан. Хуульд заасны дагуу иргэний шилжилт хөдөлгөөнийг түр зогсоохтой холбогдуулан иргэний байнга оршин суугаа газрын хаягийн бүртгэл, шилжилт хөдөлгөөний бүртгэлийг хөтлөхдөө хууль тогтоомжид заасан эх нотлох баримтын бүрдүүлбэрийг сайтар нягтлах, баталгаажуулж ажиллах талаар чиглэлийг цахимаар хүргүүлж ажилласан. Мөн 2019 оны 12 дугаар сарын 20-ны өдрөөс хойш 2020 оны 01 дүгээр сарын 09-ний байдлаар засаг захиргааны нэг нэгжээс нөгөө рүү шилжин ирсэн иргэд, нэг хаяган дээр олноор шилжин ирж байгаа иргэдийн судалгааг тус тус дүүргүүдээс гаргуулан авч, нэгтгэн ИУБГазарт хүргүүлсэн.

4. 2020 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулахад анхаарч ажиллах тухай Улсын бүртгэлийн ерөнхий газраас ирүүлсэн чиглэл;

**Хэрэгжилт:** Засгийн газрын 2019 оны 37, 38 дугаар тогтоол, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2019 оны 47 дугаар тушаал, Улсын бүртгэлийн ерөнхий газраас өгсөн үүрэг чиглэлийн дагуу тус газрын 2020 оны үйл ажиллагааны гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулан газрын даргаар батлуулж, Улсын бүртгэлийн даргаар хянуулахаар хүргүүлсэн.

5. Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1 дэх хэсэг, Иргэний улсын бүртгэлийн тухай хуулийн 19 дүгээр зүйл, Засгийн газрын 2018 оны 332 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын нутаг дэвсгэрт иргэн шилжин суурьших хөдөлгөөнийг бүртгэх, мэдээлэх журам”-ын биелэлтийг хэрэгжүүлэх талаар Улсын бүртгэлийн ерөнхий газраас ирүүлсэн чиглэл;

**Хэрэгжилт:** Иргэний шилжилт хөдөлгөөний бүртгэлд 2017 оны 07 дугаар 01-ний өдрөөс хойш бүртгэгдсэн мэдээллийг иргэний улсын бүртгэлийн цахим санд үнэн зөв бүртгэгдсэн эсэхэд тулгалт хийсэн. Мөн 2020 оны 01 дүгээр сарын 09-ний өдрөөс хойш бүртгэгдсэн бүртгэлд хяналт тавьж тайланг 7 хоног бүр Улсын бүртгэлийн ерөнхий газарт хүргүүлсэн.

6. Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2019 оны А/1051 дүгээр тушаалаар байгуулсан ажлын хэсгийн даргаас өгсөн үүрэг чиглэл;

**Хэрэгжилт:** Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2019 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн “Хороодын бүтэц, зохион байгуулалтад өөрчлөлт оруулах тухай” 25/21 дүгээр тогтоолоор нийслэлийн Налайх дүүрэгт 1, Хан-Уул дүүрэгт-5, Сонгинохайрхан дүүрэгт 11 хороо, 2019 оны 11 дүгээр сарын 22-ны өдрийн “Хороодын бүтэц, зохион байгуулалтад өөрчлөлт оруулах тухай” 8/28 тоот тогтоолоор Баянгол дүүрэгт 2 хороог шинээр байгуулахаар шийдвэрлэсэн байна.

Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2019 оны А/1051 дүгээр тушаалаар байгуулагдсан ажлын хэсгээс 2020 оны 01 дүгээр сарын 23-ны өдөр нийслэлийн газар, хэлтсийн дарга, иргэн, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тасгийн дарга нарт үүрэг, чиглэлийг өгч ажилласан.

Нийслэлийн хэмжээнд шинээр зохион байгуулагдсан 19 хороонд байнга оршин суух хаягийн бүртгэлтэй 145573 иргэний хаягийн бүртгэлд өөрчлөлтийг оруулаад байна.

7. Монгол Улсын Ерөнхий сайд, Хүүхдийн төлөө үндсэний зөвлөлийн тэргүүний 2019 оны “Төлөвлөгөө батлах тухай” 02 дугаар тогтоол, Хүүхдийн хөгжил, хамгааллын жилийн 2019-2020 оны салбар дундын ажлын төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээнээс Нийслэлийн улсын бүртгэлийн газрын хүүхдийн хөгжил, хамгааллын жилийн 2020 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг 5 арга хэмжээний хүрээнд боловсруулан газрын даргаар батлуулан хэрэгжүүлэн ажиллаж байна.

*Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн заалтын хэрэгжилт:*

1.1. Тайлангийн хугацаанд Нийслэлийн удирдах ажилтны зөвлөгөөнөөс өгсөн үүрэг даалгаврын биелэлт, Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын Зөвлөлийн хурлаас өгсөн үүрэг даалгаварын биелэлтийг хүргүүлж, Улсын бүртгэлийн ерөнхий газраас ирүүлсэн 7 үүрэг чиглэлийг хүлээн авч, үүрэг даалгаврыг хэрэгжүүлэн ажиллалаа.

1.2. Газрын 2020 оны үйл ажиллагааны гүйцэтгэлийн төлөвлөгөө, 2020 онд зохион байгуулах сургалтын төлөвлөгөө, “Нэг хот-нэг стандарт” зорилтод жилийн хүрээнд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө, терроризмаас урьдчилан сэргийлэх төлөвлөгөөнүүдийг батлан хэрэгжүүлэ, Авлигын эсрэг үндэсний хөтөлбөр, Монгол Улсын болон Нийслэлийн эдийн засаг, нийгмийн 2020 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд тусгах саналыг тус тус батлуулахаар хүргүүлэн ажиллалаа.

Нийслэлийн хэмжээнд 97 наснаас дээш өндөр настны судалгааг гарган, иргэний улсын мэдээллийн цахим санд нягтлан шалгаж, Иргэний Улсын Бүртгэлийн Газарт хүргүүлсэн.

### **7.1. Хяналт шалгалтын ажлын хүрээнд:**

Тайлангийн хугацаанд төлөвлөгөөт шалгалт 3, гэнэтийн болон төлөвлөгөөт бус шалгалт 32, өргөдөл санал гомдлын мөрөөр 542 шалгалт, нийт **577** шалгалт хийсэн байна.

2020 оны 05 дугаар сарын 25-ны байдлаар иргэний бүртгэлийн чиглэлээр 35547 бүртгэлд, эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн чиглэлээр 6265 бүртгэлд, хуулийн этгээдийн чиглэлээр 139 бүртгэлд, архивын чиглэлээр 1187 нийт **43138** бүртгэлд байнгын хяналт тавьж, 1478 зөрчил илрүүлэн, хяналтын улсын байцаагчийн 1319 дүгнэлт гарч, 11521 иргэн, хуулийн этгээдэд нийтдээ 310765000 /гучин нэгэн сая долоон зуун жаран таван мянга/ төгрөгийн торгууль ногдуулсан байна.

МУ-ын Засгийн газрын 2018 оны 332 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Монгол Улсын нутаг дэвсгэрт иргэн шилжин суурьших хөдөлөөнийг бүртгэх, мэдээлэх журам”-ын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд нийслэлийн Сонгинохайрхан, Баянгол, Хан-Уул дүүргүүдийн улсын бүртгэлийн хэлтсийн 2019 оны 12 дугаар сарын 10-ны өдрөөс 2020 оны 01 дүгээр сарын 30-ны өдрийг дуусталх хугацаанд бүртгэсэн иргэний шилжилт хөдөлгөөний бүртгэлд тус газрын хяналтын улсын байцаагч нар хяналт тавьж ажилласан байна.

Сонгинохайрхан дүүрэг дэх Улсын бүртгэлийн хэлтсийн хороодын улсын бүртгэлийн үйл ажиллагаанд Улсын бүртгэлийн ерөнхий хууль, Иргэний улсын бүртгэлийн тухай хууль, Иргэний улсын бүртгэл хөтлөх журмын хэрэгжилтийг шалгах, зөрчил гарахаас урьдчилан сэргийлэх, улсын бүртгэгчийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, мэргэжил арга зүйгээр хангах зорилгоор төлөвлөгөөт шалгалтыг 2020 оны 3 дугаар сард хяналтын улсын ахлах байцаагч хийж гүйцэтгэсэн байна. Шалгалтыг шалган туслах, дэмжин зөвлөх байдлаар хийж, улсын бүртгэгч нарт цаашид анхаарах асуудлын талаар заавар зөвлөгөөг тухай бүрт өгч ажилласан бөгөөд шалгалтаар илэрсэн зөрчлийн дахин гаргуулахгүй байх, зөрчлийн арилгах талаар иргэний улсын бүртгэлийн тасгийн дарга, улсын ахлах бүртгэгчид улсын байцаагчийн албан шаардлага хүргүүлээд байна.

Сонгинохайрхан дүүргийн Улсын бүртгэлийн хэлтсийн иргэний улсын бүртгэлийн тасгийн болон хороодын улсын бүртгэгч нарт шалгалтын дүнг танилцуулан цаашид улсын бүртгэлийн хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж ажиллах, иргэний улсын бүртгэлийн хөтлөхөд анхаарах асуудлын талаар мэргэжил арга зүйн зөвлөгөө, чиглэлийг 2020 оны 04 дүгээр сарын 09-ны өдөр өгч ажилласан байна.

## **7.2. Бүртгэлийн ажлын чиглэлээр:**

Нийслэлийн хэмжээнд 2020 оны 05 дугаар 25-ны байдлаар 734472 иргэнд иргэний бүртгэлийн үйлчилгээг газар, 9 дүүрэг болон Нийслэлийн үйлчилгээний нэгдсэн төвүүдүүдээр хүргэн ажилласан байна. Үүнд:

- ❖ Төрсний бүртгэл-15566
- ❖ Гэрлэлтийн бүртгэл-2638
- ❖ Гэрлэлт цуцлалтын бүртгэл-878
- ❖ Үрчлэлтийн бүртгэл-245
- ❖ Овог нэр өөрчлөлтийн бүртгэл-703
- ❖ Эцэг тогтоолтын бүртгэл-493
- ❖ Нас баралтын бүртгэл-3268
- ❖ Засвар өөрчлөлт-236
- ❖ Шилжин явсан-0

- ❖ Шилжин ирсэн-20850
- ❖ Хот доторх шилжилт хөдөлгөөн-30338
- ❖ Иргэний үнэмлэх олголт-63824
- ❖ Үндэсний энгийн гадаад паспорт олголт-46135
- ❖ Лавлагаа олголт-94500

Нийслэлийн хэмжээнд Эд хөрөнгө өмчлөх, эзэмших, ашиглах эрхийн улсын бүртгэлийн нэгдсэн тоон мэдээ 2020 оны 05 дугаар сарын 25-ны байдлаар /өссөн дүнгээр/ **81863** мэдүүлэг хүлээн авч, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн үйлчилгээг үзүүлсэн байна. Үүнд:

1. Анхны бүртгэл-10922
2. Өмчлөх эрх шилжих гэрээ-14295
3. Барьцааны гэрээ-45927
4. Бусад гэрээ-373
5. Бүртгэлд өөрчлөлт оруулах-3898
6. Лавлагаа, хуулбар-6024
7. Урьдчилсан тэмдэглэл-424

Батлагдсан хуваарийн дагуу улсын бүртгэгч нар эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн 28289 ш хувийн хэргийг бүртгэлийн дугаар тус бүрээр холбогдох дүүргийн бүртгэлийн хэлтэст хүлээлгэн өгч, хүлээлцсэн бүртгэлийн дэвтэрт гарын үсэг зурж баталгаажуулан авч ажилласан байна.

Дүүрэг дэх Улсын бүртгэлийн хэлтсүүдэд Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн чиглэлээр улсын бүртгэл хөтлөхтэй холбоотой гарсан алдаа зөрчлийн талаар тус газраас 2020 оны 04 дүгээр сарын 13-ны өдрийн 1/547 дугаартай албан бичгээр үүрэг чиглэлийг хүргүүлсэн.

Нийслэлийн хэмжээнд Газар эзэмших, ашиглах эрхийг улсын бүртгэлд бүртгүүлэхээр 2020 оны 01 дүгээр улирлын байдлаар иргэн, хуулийн этгээдийн нийт **12024** хүсэлтийг цахимаар мэдүүлсэн байна. Дээрхи цахимаар мэдүүлсэн мэдээллийг нягтлан шалгахад Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хуулийн 28.1-д заасан шаардлагыг хангасан 7223 иргэн, 552 хуулийн этгээдэд улсын бүртгэлийн дугаарыг хуульд заасан хугацаанд олгож, 1355 иргэн, 79 хуулийн этгээдийн хүсэлтийг эрхийн улсын бүртгэлд бүртгэхээс татгалзаж, харин хугацаа хэтэрч 2566 иргэн, 249 хуулийн этгээдэд улсын бүртгэлийн дугаарыг тус тус олгосон байна.

Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн цахим мэдээллийн санд бүртгэлтэй **2020 оны 02 дугаар сарын 15**-ны өдрөөс **2020 оны 04 дүгээр сарын 20**-ныг хүртэлх хугацааны иргэн, хуулийн этгээдийн үл хөдлөх эд хөрөнгө өмчлөх эрхийг анх удаа улсын бүртгэлд бүртгэсэн бүртгэлийг хянан үзэхэд нийт 62 бүртгэлд газрын нэгж талбарын дугаарт үндэслээгүй бүртгэсэн бүртгэлийн алдаа, зөрчлийг тус тус гаргасан талаар үүрэг чиглэлийг хүргүүлж ажилласан.

✓ Хуулийн этгээдийн эрхийн улсын бүртгэлээр нийт 128 бүртгэл хийгдэж, тэмтэгтийн хураамж 2,638,000 төгрөгийн орлогыг төвлөрүүлсэн байна. Үүнд:

- ❖ Шинээр үүсгэн байгуулсан – 28
- ❖ Нэмэлт өөрчлөлт оруулсан – 43
- ❖ Хуулийн этгээдийн лавлагаа – 3
- ❖ Бусад-7 нийт 81 бүртгэл хийсэн.

✓ **Архивын чиглэлээр хийж хэрэгжүүлсэн ажил;**

Нөхөн бүрдүүлэлт: Нийт **67470** баримт иргэний баримтын архивт хүлээн авсан. Үүнээс 9 дүүргийн бүртгэлийн хэлтсээс **56063** баримт, орон нутгийн бүртгэлийн хэлтсээс **10523** , эх нотлох баримт **884** хадгаламжийн нэгж, баримт архивт хүлээн авч, нягтлан шалган, ангилан төрөлжүүлсэн. **74782** баримтыг он цаг, нэрийн дараалалд оруулан галиглан цэгцэлсэн. Иргэний баримтын цахимжуулалтын програмаас олгосон лавлагааг үндэслэн мэдээллийн санд **446** бүртгэлийг нөхөн оруулахаар иргэний бүртгэлийн газарт албан бичгээр хүргүүлсэн. **61603** баримтыг хадгаламжийн санд байрлуулсан байна. **582** баримтыг хувийн хэрэгжүүлсэн. Хадгалах хугацаа дууссан **4084** баримтыг хадгаламжийн нэгжээс түүвэрлэсэн. Архивын баримтын хадгалалт хамгаалалт: Сан хөмрөгийн чийг дулааныг өдөр бүр хэмжин тэмдэглэл хөтөлж, зохих арга хэмжээг тухай бүр авч ажилласан. Мөн цэвэрлэгээний хуваарь гарган, баталж, хяналт тогтмол тавьж ажиллаж байна. **12158** баримтыг сэлбэн зассан. Архивын баримтын ашиглалт: Нийт **28570** лавлагаа олгосон. Үүнээс хууль хяналтын болон төрийн байгууллагын хүсэлтээр 25125, иргэнд 3445 лавлагаа, олгосон байна. Нөхөн бүртгэл, хяналтын улсын байцаагчийн дүгнэлтэнд, лавлагаа мэдээлэл олгох зэрэгт **294** баримтыг архиваас шүүн, буцаан байрлуулсан. **19511** баримтыг сүлжээнд нягтлан шалган, холбогдох газарт хүргүүлэх, сан хөмрөгт байрлуулах ажлуудыг хийсэн. **122** баримтыг хуулбарлан холбогдох ажилтан, иргэнд олгосон. Сан хөмрөг №1, 3-т тоо бүртгэлийг шинэчлэн хөтлөх зорилгоор хадгаламжийн нэгжид тооллогыг өөрсдийн хүчээр эхлүүлэн 2020 оны 02 дугаар сарын 20-ноос 2020 оны 06 дугаар сарын 10-ны өдрийг дуустал нийт **4293** ХН, **480274** хувийн хэрэг, **640208** хуудас баримтыг тоолоод байна.

Улсын онцгой комиссын шийдвэрээр Коронавирусын тусгаарлалтанд байгаа 4386 иргэний хаяг байршилыг 2020.04.12-15-ны өдрүүдэд гарган хүргүүлсэн

Архивын арга зүйн ажил: Дүүргийн архивын ажилд мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх, шаардлагатай тоног төхөөрөмж, архивын хайрцаг, дугтуй , бичиг хэргийн материал, гал уснаас хамгаалах галын хор, хулдаас , гэрэл чийдэн, чийгшүүлэгч аппарат гэх зэрэг эд хогшлын судалгааг авч санхүүд танилцуулан, биелэлтэнд нь анхаарч ажиллаж байна. Хан-Уул, Чингэлтэй, Баянзүрх, Баянгол, Багахангай, Налайх дүүргүүдийн архивт 40 ширхэг галын хор, НУБГ болон 9 дүүргийн хэлтсийн архивч нарт ажлын халад 22 ширхэгийг захиалан хийлгүүлсэн ба архивын байранд шаардлагатай чийгшүүлэгч 14 ш, ус тавих түмпэн 50 ш, ажлын бээлий 100 ширхэгийг тус авч тараан хүргүүлсэн.

Хэлтсийн дарга, ахлах мэргэжилтэн нар 2020.04.09-10-ны өдрүүдэд төвийн 6 дүүргийн архивын өнөөгийн байр байдалтай танилцаж, тодорхой чиглэл өгөн, газрын даргад илтгэх хуудсаар танилцуулсан.

Улсын бүртгэлийн ерөнхий газар, Архивын ерөнхий газрын хамтаран баталсан “Хадгалах хугацааны жагсаалт”-ыг шинэчлэн батлах чиглэлээр явуулсан санал асуулгад тодорхой асуудлын хүрээнд саналаа тусгаж, хүргүүлсэн.



2020 онд Архивын ерөнхий газраас зохион байгуулсан архивчийн мэргэжил олгох сургалтанд архивч нарыг 06 дугаар сарын 02-ноос 06 дугаар сарын 22-ны өдрийн хооронд хамруулсан.

Тус газраас дүүргүүдийн лавлагаа олгодог улсын бүртгэгч нарт иргэний бүртгэлийн мэдээллийн сангаас лавлагаа хэрхэн олгох, “Мэдээлэл удирдах програм” дээр ажиллах талаар сургалт явуулан мэдээлэл арга зүйгээр ханган ажиллаж байна.

Улсын бүртгэлийн эх нотлох баримт бичгийг архивт хадгалах журмын 4.7-г хэрэгжүүлэх зорилгоор “АРХИВТ ХҮЛЭЭН АВАВ” тэмдэг 18 ширхэгийг захиалан хийлгүүлж, хэлтсийн архивч нарт болон дүүргүүдийн архивч нарт хүлээлгэн өгсөн.

#### 1.4 Санхүү, аж ахуйн чиглэлээр:

2020 оны эхний хагас жилийн байдлаар:

№	Хугацаа	Орлого, зардлын зүйл анги	Үйлчилгээний төрөл	Мөнгөн дүн /өссөн дүнгээр/
1	2020 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн байдлаар	Улсын төсөвт	Үйлчилгээний орлого	3 тэрбум 420 сая төгрөг
2		Орон нутгийн төсөв	Торгууль шийтгэврийн орлого	69 сая төгрөг
Нийт 3 тэрбум, 489 төгрөг				

1.4.1 Улсын Бүртгэлийн Ерөнхий газар болон бусад санхүүжилтээр хүлээн авсан үндсэн хөрөнгийг Өмчийн харилцааны ерөнхий газрын програмд 2020 оны 01 дүгээр сарын 15-аас 02 дугаар сарын 15-ны хооронд шивж баталгаажуулан тайлагнасан.

- Нийслэлийн улсын бүртгэлийн газрын нийт хэлтэс, нэгжүүдийн 2020 оны 01-р сарын 02-ноос 2020 оны 05-р сарын 25-нийг хүртэлх хугацаанд бүртгэлийн үйл ажиллагааны явцад техникийн алдаанаас 699, улсын бүртгэгчийн алдаанаас 1064, нийт 1763 ширхэг хүчингүй болсон үнэт цаасны жагсаалт гарган бэлдсэн.
- Дүүргүүдийн бүртгэлийн хэлтэс, нэгдсэн үйлчилгээний төвүүдийн тооцоо бодсон актыг батлагдсан хугацаанд сар бүр хүлээн авч санхүүгийн програмд шивж үлдэгдлийг баталгаажуулан хэлтэс нэгжийн нярав, эд хариуцагч нартай үнэт цаасны үлдэгдлийг тулган баталгаажуулсан.
- Газрын нийт үйлчилгээний 3.462.327.766 төгрөгийн орлогыг цаг тухай бүрт нь дансны хуулгатай тулган шалгаж улсын төсөвт төвлөрүүлсэн.
- Иргэдийн үйлчилгээний орлого буруу тушаасан өргөдлийг цаг тухай бүрт шийдвэрлэж шилжүүлсэн.
- Улсын бүртгэлийн ерөнхий газрын санхүүжилтээр 25,1 сая төгрөгний үндсэн хөрөнгийг хүлээн авч 9-н дүүрэг 4-н нэгдсэн үйлчилгээний төвд хүлээлгэн өгсөн.
- Чингэлтэй дүүргийн засаг даргын тамгын газрын хөрөнгө оруулалтаар олгосон 39.413.000 төгрөгийн үнэтэй 1 ширхэг өсгөгч, 1 ширхэг зурагт (Philips 70 PUF7364/T3

- 4K Smart), 1 ширхэг зургийн аппарат (Canon EOS 750D), 1 ширхэг компьютер (Apple iMac), 2 ширхэг компьютер (Dell OptiPlex 7470), 7 ширхэг компьютер (Dell Vostro 3671), 5 ширхэг принтер (HP Laserjet M28a), 1 ширхэг преоктор (Epson CB-S05E), 2 ширхэг скайнер (Epson DS-530), 1 ширхэг хөлтэй самбарыг үндсэн хөрөнгийн дансанд, 572.000 төгрөгийн үнэтэй 1 ширхэг преокторын дэлгэц хөлтэй, 1 ширхэг тасалгааны үнэртүүлэгчийг бусад хангамжийн материалын дансанд бүртгэж авч хүлээлгэн өгсөн.
- Нийслэлийн засаг даргын тамгын газрын хөрөнгө оруулалтаар олгосон 80.740.032 төгрөгийн үнэтэй 24 ширхэг хурууны хээ, чип уншигч (Futronic FS82), 24 ширхэг хурууны хээний сканнер (Crossmatch EF200), 24 ширхэг зургийн аппаратыг (Canon 4000D) үндсэн хөрөнгийн дансанд, 7.963.968 төгрөгийн үнэтэй 24 ширхэг зургийн аппаратны хөл (Yunteng VCT-690), 24 ширхэг зураг авах арын фоныг бусад хангамжийн материалын дансанд бүртгэж авч 6-н дүүрэгт хүлээлгэн өгсөн.
  - Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2020 онд шинэчилсэн бүртгэлийн үйлчилгээг үзүүлж эхлэх 10 хороонд тус бүр 7 төрлийн тоног төхөөрөмж шинээр олгохоор болсон бөгөөд одоогийн байдлаар 47195500 /дөчин долоон сая нэг зуун ерэн таван мянга таван зуу/ төгрөгийн үнэ бүхий 3 төрлийн 30 ширхэг тоног төхөөрөмж хүлээн аваад байна.
  - Нийслэлийн Улсын Бүртгэлийн газарт ашиглагдаж байсан нийт 230,975,139.0 /хоёр зуун гучин сая есөн зуун далан таван мянга нэг зуун гучин есөн/ төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий үндсэн хөрөнгийг акталж, данс бүртгэлээс хасах ажлыг хийж өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналтан дор гүйцэтгэсэн.
  - Данснаас хасагдаж буй хөрөнгөнөөс 25 нэр төрлийн 29,155,345.0 /хорин есөн сая нэг зуун тавин таван мянга гурван зуун дөчин таван/ төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий дараах хөрөнгийг устгасан.
    - **Тавилга, аж ахуйн эд хогшил, машин тоног төхөөрөмж:**
      - бичгийн ширээ 15 төрлийн 55 ширхэг бүхий 17.429.390.00 төгрөгийн өртөгтэй
      - майхан 1 ширхэг 2.075.700.00 төгрөгийн өртөгтэй
      - үйлчилгээний тейк 3 ширхэг 5.071.460 төгрөгийн өртөгтэй
      - шар тумпочка 3 ширхэг 352.039.00 төгрөгийн өртөгтэй хөрөнгийг устгалд оруулан ачуулж данснаас хассан.
      - Сейф 18 ширхэг 1758240 төгрөгийн өртөгтэй хөрөнгийг актлаж архивын тавиурт төмөр тавцан, хаалт хийж ашигласан.
    - **Програм хангамж**
      - програм хангамж MC 3 ширхэг 2.197.966.17 төгрөгийн өртөгтэй
      - бүртгэлийн мэдээлэл боловсруулах 1 ширхэг 270.550.00 төгрөгийн өртөгтэй тус тус хөрөнгийг устгаж данснаас хассан.
  - Данснаас хасагдаж буй 75 нэр төрлийн 201,819,793.0 /хоёр зуун нэгэн сая найман зуун арван есөн мянга долоон зуун ерэн гурав/ төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хөрөнгийг нэр төрлөөр нь ялгаж Өмч ашиглалт удирдлагын газарт актаар хүлээлгэн өгсөн.
  - Газрын болон дүүргүүдийн иргэний бүртгэлийн ажилтнуудад байнга хэрэглэгддэг гэрчилгээ, баталгаа, ХААТР маягт болон бусад үнэт цаасыг УБЕГ-аас Төрсний гэрчилгээ А4-44000, Бичвэргүй ХААТР 25000, Бичвэргүй 21-60000, ИҮДОӨргөдөл 42500, ХААТР-31-40000, Нас баралтын гэрчилгээ 8000, Лавлагаа А4-20000, Лавлагаа А5-40000, Төрсний гэрчилгээний хавтас-4000, Гэрлэлтийн баталгааны хавтас-3200,



Үл хөдлөх гэрчилгээ 36000, Эд хөрөнгийн цэнхэр хавтас 2188, Эд хөрөнгийн хувийн хэргийн хавтас 60000, Гадаад паспортын ягаан хуудас 51000, УБДүгнэлт 4000, Лавлагаа А4-76000, Лавлагаа А5-72000, Шийтгэлийн хуудас-20000, Мэдүүлэгийн хуудас-300000 ширхэг үнэт цаас, холбогдох иргэний болон эд хөрөнгийн холбогдолтой дэвтэр маягт 5976 ширхэг буюу 34 төрөл 208985021,50 төгрөгийн үнэт цаас татан авч дүүргүүдэд Үл хөдлөхийн гэрчилгээ 30400, Гэрлэлтийн баталгаа А-4-2500, Улсын байцаагчийн дүгнэлт 3440, Гадаад паспортын ягаан хуудас 44000, Улсын байцаагчын акт 20, мэдэгдэл албан шаардлага нийт 190, Бичвэргүй ХААТР 28500, Бичвэргүй 21-63000, Газрын гэрчилгээ 7700, Гэрлэлтийн хавтас 3670, ИҮДОӨргөдөл 76500, ХААТР22-19000, Лавлагаа А4-71500, Лавлагаа А5-59000, Нас баралтын гэрчилгээ 4216, Төрсны гэрчилгээ А4-29500, Төрөлтын хавтас 30300, ХААТР31-37000, Шийтгэл 9300, Дэвтэр маягт 10 нэр төрөл буюу 818, Иргэний мэдүүлэг 526000, Хувийн хэргийн хавтас 118000, Хувийн хэрэг 4800, Газар эзэмших гэрчилгээ-7700 ширхэг 211281354 төгрөгны үнэт цаас дүүргүүдэд тараан олгосон.

- Энэ хугацаанд бичиг хэргийн материал нийт төгрөгийн давхардсан тоогоор 72208 нэр төрлийн 131778750 төгрөгийн орлого авч 69193 ширхэг нэр төрлийн 122998720 төгрөгийн материалын зарлага, Аж ахуйн материалын 18714129 төгрөгийн давхардсан тоогоор 13605 нэр төрлийн орлого авч, зарлага 18340379 төгрөгийн 13473 ширхэг нэр төрлийн материал, Сэлбэг хэрэгсэл 2371779 төгрөгийн материал авч буцаан олгосон, Түлш шатах тослох материал 7170000 төгрөгийн шатахуун авч 7465000 төгрөгийн шатахуун олгон, Бусад хангамжийн материал 16360 нэр төрлийн 13630668 төгрөгний зардал олгон нийслэлийн бүртгэлийн газар болон 4 төв, 9 дүүргүүдийн иргэний болон эд хөрөнгийн бүртгэлийн ажилтнуудад 2020 оны 1-р улиралд хангалт хийгээд байна. Жижиг мөнгөн сангаар 24000000 төгрөг авч зарцуулан төрийн санд тайлагнаж дууссан. Мөн кассаар дамжин хийгдсэн Цар тахалтай холбоотой арга хэмжээнд зарцуулан гарсан мөнгөн хөрөнгийг санхүү бүртгэлийн хууль дүрмийн дагуу холбогдох баримтуудыг хавсарган мөнгөн хөрөнгийн тайланг хийж гүйцэтгэсэн.
- Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах, мэдээлэл байрлуулах зөвлөмжийн дагуу сар бүрийн төсвийн гүйцэтгэлийн тайлан, тайлбар, тушаал шийдвэрийг цаг тухай бүрд оруулж ажилласан.

### **1.5. Албан хэрэг хөтлөлтийн талаар:**

Баримт бичгийн шийдвэрлэлт болон бусад мэдээллийн эрэлт хайлтыг шуурхай болгох үүднээс газарт ирсэн баримт бичгийг “Албан хэрэг хөтлөлтийн E-DOC програм”-д бүртгэн компьютерийн санамжид оруулан ажиллалаа.

6 дугаар сарын 15-ны өдрийн байдлаар 835 албан бичгийн төслийг албан хаагчдаас хүлээн авч, удирдлагаар батлуулан, хэвлэмэл хуудсанд буулгаж, нэгдсэн дугаар олгон, edoc системд бүртгэсэн байна. Дээрх албан бичгээс 651 албан бичиг edoc системээр хүргэгдсэн байна.

2020 оны эхний хагас жилд edoc системээр 2231, байгууллага дээр 2434, нийт 4700 албан бичиг хүлээн авч бүртгэж, удирдлагад танилцуулж, холбогдох албан хаагчдад шилжүүлж, шийдвэрлэлтэд хяналт тавин ажилласан байна. Дээрх албан бичгийн 3005 нь

хариутай албан бичиг байсан бөгөөд тус газрын албан бичиг шийдвэрлэлтийн дундаж хоног 7.88 байна.

Албан бичиг шийдвэрлэлтийн хувь 100 байна.

Мөн хугацаанд 3011 албан бичгийн шийдвэрлэлтэд edoc системээр хяналт хийсэн байна.

Албан хаагчдаас үндсэн үйл ажиллагааны чиглэлээр 12, хүний нөөцийн чиглэлээр 19, нийт 31 тушаалын төслийг хүлээн авч хэвлэмэл хуудсанд буулгаж, даргаар гарын үсэг зуруулж, нэгдсэн дугаар олгож албажуулсан байна.

а/ Өмнөх онд хөтлөгдсөн байнга хадгалах 43, 70 жил хадгалах 26, түр хадгалах 478 ширхэг хадгаламжийн нэгжийг батлагдсан хуваарийн дагуу холбогдох хэлтэс, нэгжүүдээс хүлээн авч, архивт нөхөн бүрдүүлэлт хийлээ.

б/ Архивт баримт шилжүүлэх үед хадгаламжийн нэгжид нягтлан шалгалт хийсэн.

в/ Хүлээн авсан хадгаламжийн нэгжид хадгалах хугацааны ангиллаар данс бүртгэл үйлдсэн.

г/ 2019 оны удирдлагаас үндсэн үйл ажиллагааны чиглэлээр гарсан 39, хүний нөөцийн чиглэлээр гарсан 117 тушаалыг ERP програмын archive edoc системд нөхөн бүрдүүлэлт хийсэн байна.

а./ Архивын цэвэрлэгээ, үйлчилгээ хуваарийн дагуу тогтмол хийгдэж байна.

б./ Байгууллагын архивын чийг, дулааныг өдөр тутам тогтмол хэмжиж, тэмдэглэл хөтөлж байна.

2019 онд тус газрын даргаас үндсэн үйл ажиллагааны чиглэлээр гарсан 39, хүний нөөцийн чиглэлээр гарсан 117 тушаал, тус газарт ирсэн 8638, явуулсан 1570 албан бичиг болон бусад баримт материалаар хадгаламжийн нэгж үүсгэн байгууллагын архивт нөхөн бүрдүүлэлт хийсэн.

Албан хаагчдын албан хэрэгцээнд архивын баримт ашиглуулахдаа бүртгэлийг тогтмол хөтөлж байна.

Хэвлэмэл хуудсны тайланг хүлээн авч, хүчингүй болсон хэвлэмэл хуудас байхгүй байна.

Дотоод хэлтсийн ажилтнуудын гадуур ажиллах ажилтны бүртгэлийн дэвтэрийг өдөр тутам хөтөлж байна.

***Иргэдээс ирүүлсэн өргөдөл гомдлын мэдээ:***

Тайлангийн хугацаанд тус газарт иргэн, байгууллагаас нийт 167 өргөдөл ирсэн байх бөгөөд үүнээс гомдол- 113, санал хүсэлт – 54 ирсэн байна. Өргөдөл, гомдол, санал хүсэлтийн шийдвэрлэлтийг сайжруулах зорилгоор ажлын төлөвлөгөө боловсруулан, хуулийн хүрээнд шийдвэрлэлтийн хүрээнд сйжруулалтын арга хэмжээ эвч ажиллаж байна.

Мөн Нийслэлийн Засаг даргын тамгын Газрын ERP.Ulaanbaatar.mn системд тус газрын дүүрэг дэх Улсын бүртгэлийн хэлтсүүдийг байгууллагын дотоод нэгжүүдэд шилжүүлэх хүсэлт хүргүүлэв. Энэ нь өргөдөл, гомдол санал хүсэлтийг шийдвэрлэх шат дамжлагыг бууруулах ач холбогдолтой байна. Нийт өргөдлийг задалбал:

№	Агуулга	Тухайн улиралд	Өссөн дүнгээр
---	---------	----------------	---------------

1	Гомдлын агуулга	Тухайн газар, хэлтсийн бүтэц, зохион байгуулалт, орон тоо, ерөнхий зохион байгуулалттай холбоотой	6	17
2		ИБ-ийн үйл ажиллагаатай холбоотой	15	34
3		Лавлагаа мэдээлэл болон архивын үйл ажиллагаатай холбоотой	0	2
4		Гадаадад зорчих эрхийн улсын бүртгэлтэй холбоотой	0	2
5		ЭХЭБ-ийн үйл ажиллагаатай холбоотой	20	26
6		ХЭБ-ийн үйл ажиллагаатай холбоотой	0	0
7		Бүртгэлийн хяналтын үйл ажиллагаатай холбоотой	0	0
8		Төрийн үйлчилгээний цахим машинтай холбоотой асуудлаар /ТҮЦ машинаас олгосон лавлагаагаар бусад байгууллага үйлчлэхгүй байх гэх мэт/	0	0
9		Шилжилт хөдөлгөөнтэй холбоотой асуудлаар ирүүлсэн	1	4
10		Санхүүгийн үйл ажиллагаатай холбоотой	0	0
11		Албан хаагчийн зан харьцаатай , ёс зүйтэй холбоотой ажлын хариуцлага алдсан тухай	11	22
12		Удирдлага албан тушаалтны үйл ажиллагаа, хариуцлага, ёс зүйн талаар	2	3
13		Бусад	0	3
14		<b>Дүн, мөр 14=(мөр1+2+....+13)</b>	<b>55</b>	<b>113</b>
15	Санал, хүсэлтийн агуулга	Тухайн газар, хэлтсийн бүтэц, зохион байгуулалт, орон тоо, ерөнхий зохион байгуулалттай холбоотой	4	5
16		ИБ-ийн үйл ажиллагаатай холбоотой	14	27
17		Лавлагаа мэдээлэл болон архивын үйл ажиллагаатай холбоотой	0	0
18		Гадаадад зорчих эрхийн улсын бүртгэлтэй холбоотой	0	5
19		ЭХЭБ-ийн үйл ажиллагаатай холбоотой	9	13
20		ХЭБ-ийн үйл ажиллагаатай холбоотой	0	0
21		Бүртгэлийн хяналтын үйл ажиллагаатай холбоотой	1	1
22		Төрийн үйлчилгээний цахим машинтай холбоотой асуудлаар /ТҮЦ машинаас олгосон лавлагаагаар бусад байгууллага үйлчлэхгүй байх гэх мэт/		0
23		Шилжилт хөдөлгөөнтэй холбоотой асуудлаар ирүүлсэн	0	1
24		Албан хаагчийн нийгмийн асуудал болон хүний нөөцтэй холбоотой асуудал	0	0

25		Санхүүгийн үйл ажиллагаатай холбоотой /тэтгэмж хүсэх , тэмдэгтийн хураамжын буцаалт, гэх мэт/	0	0
26		Бусад	1	1
27		Талархал	0	1
28		Санал	0	0
29		Мэдэгдэл	0	0
30		<b>Дүн, мөр 30=(мөр15+16+....+29)</b>		<b>29</b>
31	Нийт өргөдөл, гомдлын агуулга	Тухайн газар, хэлтсийн бүтэц, зохион байгуулалт, орон тоо, ерөнхий зохион байгуулалттай холбоотой	10	22
32		ИБ-ийн үйл ажиллагаатай холбоотой	29	61
33		Лавлагаа мэдээлэл болон архивын үйл ажиллагаатай холбоотой	0	2
34		Гадаадад зорчих эрхийн улсын бүртгэлтэй холбоотой	0	7
35		ЭХЭБ-ийн үйл ажиллагаатай холбоотой	29	39
36		ХЭБ-ийн үйл ажиллагаатай холбоотой		
37		Бүртгэлийн хяналтын үйл ажиллагаатай холбоотой	1	1
38		Төрийн үйлчилгээний цахим машинтай холбоотой асуудлаар /ТҮЦ машинаас олгосон лавлагаагаар бусад байгууллага үйлчлэхгүй байх гэх мэт/	0	0
39		Шилжилт хөдөлгөөнтэй холбоотой асуудлаар ирүүлсэн	1	5
40		Санхүүгийн үйл ажиллагаатай холбоотой	0	0
41		Албан хаагчийн зан харьцаатай , ёс зүйтэй холбоотой ажлын хариуцлага алдсан тухай	10	22
42		Албан хаагчийн нийгмийн асуудал болон хүний нөөцтэй холбоотой асуудал	3	3
43		Бусад	1	4
44		Талархал	0	1
45		Санал	0	0
46		Мэдэгдэл	0	0
47		<b>Дүн, мөр 47=(мөр31+32+....+46)</b>		<b>84</b>

2.Гомдол, санал хүсэлт ирүүлсэн эх сурвалжийг авч үзвэл:

1	Нийт ирсэн өргөдөл, гомдол, санал хүсэлт бүгд		Нийт 167
2	Үү нэ	Бичгээр	80

3		Утсаар хандсан	0
4		Биечлэн уулзсан	10
5		Дээд газраас ирүүлсэн	0
6	Бусад	ЗГ 11-11	18
9		1800-1200, 1800-1890 дугаарын оператороос	47
10		цахимаар	12
Нийт			167

**3. Шийдвэрлэсэн байдал:**

1	Нийт ирсэн өргөдөл, гомдол, санал хүсэлт бүгд		167
2	Шийдвэрлэлт	Шийдвэрлэж хариу өгсөн	152
3		Бусад байгууллагад шилжүүлсэн	0
4		Хугацаа хэтрүүлж шийдвэрлэсэн	0
5		Хугацаа болоогүй	15
6		Шийдвэрлэлт, хувиар	91%

Тус газрын өргөдөл гомдлын шийдвэрлэлт 100 хувь, шийдвэрлэлтийн хугацаа 12 хоног, 1 цаг, 2 минут. Энэ нь нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн дундаж хугацаанаад шийдвэрлэсэн үзүүлэлттэй байна.

**1.6. Хүний нөөцийн чиглэлээр:**

2019 оны ХАСХОМ шинэчлэн гаргасан 313, шинээр томилогдсон 46, их хэмжээний өөрчлөлт мэдүүлсэн 1 албан хаагч байна. Мэдүүлэхээс татгалзсан болон хуулийн хугацаанаас хожимдуулж мэдүүлсэн албан хаагч байхгүй.

Төрийн захиргааны 316 албан хаагчийн ажилласан жил болон зэрэг дэвийн судалгааг гарган Улсын бүртгэлийн ерөнхий газарт хүргүүлсэн.

Захиргааны хэлтэс, Бүртгэлийн хэлтэс, Архивын хэлтэс, Багахангай, Сонгинохайрхан дүүрэг, Баянгол, Баянзүрх, Налайх дүүргийн албан хаагчдын ажлын үнэмлэхийг шинээр хэвлэх, болон сунгах ажлыг хийж дуусгасан. Шинээр томилогдсон болон сунгалтын хугацаа дууссан 29 албан хаагчийн ажлын газрын үнэмлэхийг шинээр хэвлүүлж олгосон.

2020 оны 01 дүгээр сарын 07-нд Нийслэлийн Засаг даргын Тамгын газраас зохион байгуулсан “Жендерийн тэгш байдал” сэдэвт сургалтанд хамрагдсан.

“Хүний нөөцийн удирдлага, хяналтын нэгдсэн систем”-д төрийн захиргааны 27 албан хаагчийн мэдээллийг шинэчлэн бүртгэж, баталгаажуулсан.

Ковид-19 –тэй холбогдуулан урьдчилан сэргийлэх зорилгоор албан хаагчдын цаг бүртгэлийг хурууны хээгээр авахыг хориглосон.

0-12 насны хүүхэдтэй 183 албан хаагчин судалгаа гаргаж Улсын бүртгэлийн е Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2020 оны 02 дугаар сарын 12-ны өдрийн 10 дугаар зарлиг, Нийслэлийн Засаг Даргын А/198, А/165, А/191 тоот захирамжийн дагуу шинэ коронавирус халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, иргэд аж ахуйн нэгж байгууллагад зөвлөгөө зөвлөмж гарын авлага тараан, халдваргүйжүүлэлт хийсэн эсэхэд хяналт тавьж, иргэдэд маскаа тогтмол зүүх талаар зөвлөгөө өгч ажиллах албан хаагчдын хуваарийг гаргасан.

Баянхошуу, Хороолол чиглэлд Нийслэлийн үйлчилгээний нэгдсэн төв шинээр нээхтэй холбогдуулан тэнд ажиллах албан хаагчийн тоо, цалин хөлсний судалгаа гаргасан.

Албан хаагчдын орон сууцны судалгаа гарган Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлсэн. Ерөнхий газарт мөн Газрын төрийн үйлчилгээний албан хаагчдын тоог нэмэгдүүлэх, ангилалыг нэмэх асуудлаар Улсын бүртгэлийн ерөнхий газарт санал хүргүүлсэн.

Газрын төрийн үйлчилгээний албан хаагчдын тоог нэмэгдүүлэх, ангилалыг нэмэх асуудлаар Улсын бүртгэлийн ерөнхий газарт санал хүргүүлсэн.

Төрийн дээд шагналаар шагнуулах 9 албан хаагчдын анкет, ажил байдлын тодорхойлолт, өмнө шагнуулсан шагналын хуулбар зэргийг хүлээн авч хянан Улсын бүртгэлийн ерөнхий газарт хүргүүлсэн.

Засгийн газрын шагналд нэр дэвшүүлэх шаардлага хангасан 11 албан хаагчийн анкет, ажил байдлын тодорхойлолт, өмнө шагнуулсан шагналын хуулбар зэргийг хүлээн авч хянан Улсын бүртгэлийн ерөнхий газарт хүргүүлсэн.

Тагнуулын ерөнхий газраас ирүүлсэн зөвшөөрлийг үндэслэн итгэмжлэгдсэн ажилтан томилох тухай тушаалын төсөл бэлтгэн албажуулсан.

Монгол Улсын Их Хурлын 2020 оны эелижт сонгууль явагдахтай холбогдуулан хорооны улсын бүртгэгч нарыг итгэмжлэгдсэн ажилтны нөөцөд бүртгүүлэхээр 150 албан хаагчийн нэр, регистрийн дугаар, утасны дугаар бүхий судалгаа гарган, Бүртгэлийн хэлтэст хүлээлгэн өгсөн.

Улсын бүртгэлийн ерөнхий газраас ирүүлсэн итгэмжлэгдсэн ажилтнаар “Ажил гүйцэтгүүлэх гэрээ”-г хүлээн авч хэвлэлтэнд бэлтгэн хэвлэсэн. 9 дүүргийн улсын бүртгэлийн хэлтсийн удирдах албан тушаалтанд 884 итгэмжлэгдсэн ажилтны 3 хувь гэрээг хүлээлгэн өгсөн. Гэрээ байгуулагдсаны дараа ажилтан тус бүрийн 2 хувь гэрээг буцааж хураан авсан. 884 итгэмжлэгдсэн ажилтны үнэмлэхийг дугаарлан албажуулж олгосон.

366 албан хаагчаас нууцын баталгаа гаргуулан авсан.

Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын дагуу газрын даргын тушаалаар төрийн үйлчилгээний 25 албан хаагчид төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийг шинээр, төрийн захиргааны 60 албан хаагчийн төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийг шинэчлэн тогтоож олгосон.



Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2020.03.20-ны Б/155 дугаар тушаалаар 117 албан хаагчид зэрэг дэв шинээр, 147 албан хаагчийн зэрэг дэвийг ахиулан тогтоолгосон. Нийт 264 албан хаагчийн албан тушаалын зэрэг дэв өөрчлөгдсөн байна.

*Сургалт, мэргэжил, арга зүйгээр ханган ажиллах чиглэлээр:*

Нийслэл дэх Улсын бүртгэлийн газрын сургалтын төлөвлөгөөтэй уялдуулан “Нийслэл дэх Улсын бүртгэлийн газрын 2020 оны сургалтын үйл ажиллагааны төлөвлөгөө”-г газрын даргаар батлуулан хэрэгжилтийг ханган ажиллав.

Тайлангийн хугацаанд зохион байгуулагдсан сургалтууд:

д/д	Сургалт зохион байгуулсан байгууллагын нэр	Зориулалт	Сургалтын сэдэв	Хамрагдсан ажилтан, албан хаагчид /харилцагчид/-ын тоо
1	УБЕГ	Ажилтнуудад	Удирдах ажилтны цахим сургалт	15
2			Бичиг хэргийн ажилтнуудад зориулсан онлайн сургалт	10
3			"Нийгмийн үйлчилгээний хүртээмжийг сайжруулах зорилгоор бүртгэлийн системийг боловсронгуй болгох" Иргэний улсын ахлах бүртгэгч нарт зориулсан сургалт	15
4			Бодлого төлөвлөлт, дүн шинжилгээний газраас зохион байгуулсан 2020 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулахад анхаарах асуудлууд	35
5			Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд албан хаагчдад сонгуулийн тухай хууль тогтоомжийг таниулах, зөвлөмж чиглэл өгөх	40
6			Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл хөтлөхөд гарч буй нийтлэг алдаа, цахим системийн боловсруулалтад анхаарах асуудлуудын талаар зөвлөмж чиглэл өгөх, зөрчлөөс урьдчилан сэргийлэх з	41
7			Улсын бүртгэгч бэлтгэх сургалт	12
			НИЙТ _7 СУРГАЛТ	168
8	Нийслэл дэх		“Улсын бүртгэлийн байгууллагын	214 албан

	Улсын бүртгэлийн газар		итгэмжлэгдсэн ажилтанд зориулсан эрх зүйн цахим сургалт	хаагч 855 итгэмжлэгдсэн ажилтан
9			Авилгатай тэмцэх ажлын хүрээнд “Байгууллагын үйл ажиллагааны ил тод байдал” \ Цахим сургалт\	217
10			Бичиг хэрэг, өргөдөл гомдол хариуцсан албан хаагчдад зориулсан сургалт	10
11			"Дархлаагаа хамгаалах нь"	17
			НИЙТ 4 СУРГАЛТ	1313
12	Дүүрэг дэх Улсын бүртгэлийн хэлтэс		СНЖ-д өөрчлөлт оруулах журам	194
13	Баянзүрх дүүрэг дэх Улсын бүртгэлийн хэлтэс		Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль	20
14	Баянзүрх дүүрэг дэх Улсын бүртгэлийн хэлтэс	Ажилтнуудад	Соёлын өвийн тухай ойлголт	13
15	Чингэлтэй дүүрэг дэх Улсын бүртгэлийн хэлтэс		Гэрээр ажилтанд зориулсан	1
	НИЙТ 8 арга хэмжээ			1541
	<b>НИЙТ 15 удаагийн сургалт \Ажилтанд зориулсан\</b>			<b>1709</b>
1	Баянзүрх дүүрэг дэх Улсын бүртгэлийн хэлтэс	Харилцагчдад	Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль	20
2	Чингэлтэй дүүрэг дэх Улсын бүртгэлийн хэлтэс		Иргэний үнэмлэх бүртгэл /1-р хорооны улсын бүртгэгч/	5

”Хуулийн этгээдийн улсын бүртгэгч нарт зориулсан сургалт”, “Хяналтын улсын байцаагч нарт зориулсан сургалт”, “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх цахим сургалт”, “Хүүхдийн эрх, аюулгүй байдлыг хангах тухай онлайн сургалт”, “Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд зохион байгуулах цахим сургалт” зэрэг цахим сургалтуудад Нийслэл, дүүрэг дэх Улсын бүртгэлийн газар, хэлтсийн албан хаагч нар оролцов.

Албан хаагчдыг мэргэшүүлэх, мэдлэг мэдээллийг сайжруулах зорилгоор Улсын бүртгэлийн ерөнхий газраас 7, Нийслэл дэх Улсын бүртгэлийн газраас дүүрэг дэх хэлтсүүдэд 8 удаа нийт 15 удаагийн сургалтаар давхардсан тоогоор 1709 албан хаагч хамрагдсан байна.

**1.8. Нээлттэй хаалга арга хэмжээ, ёслолтой бүртгэлийн арга хэмжээний хүрээнд:**

- Хөгжлийн бэрхшээлтэй гэрээс гарч чададгүй, хөгжлийн бэрхшээлтэй 4 иргэний биеийн давхцахгүй өгөгдлийн /гарын хурууны хээ/ бүртгэл, хүндэтгэн үзэх шалтгаантай 2 ээжийн аав нь Зэвсэгт хүчний дугаар ангид цэргийн алба хааж байгаа 1 хүүхдийн төрөлтийн бүртгэлийг гэрээр болон цэргийн анги дээр нь очиж бүртгэж нийт 7 захиалгат бүртгэл хийж ажилласан.
- 2020 оны 05 дугаар сарын 15-ны өдөр болсон Гэр бүлийн өдрөөр залуу гэр бүлийг дэмжиж ёслолтойгоор шинээр баригдсан орон сууцны гэрчилгээг гаргаж гардуулав.
- Дэлхий гэр бүлийн өдрийг тохиолдуулан шинээр төрсөн хүүхдийн төрсний гэрчилгээг, гэрлэлтээ батлуулж буй хосын гэрлэсний бүртгэлийг ёслолтой гардуулах үйл ажиллагааг зохион байгуулж ажилласан байна.
- Зэвсэгт хүчний 120 дугаар цэргийн анги дээр очиж төрсний бүртгэлийг бүртгэж ажилласан.
- 2020.04.03-ны өдөр Хан-Уул дүүргийн 1 дүгээр хорооны иргэн М.Нанзаддорж О.Сэлэнгэ нарын гэр бүл 2020.03.21-ний өдөр Эх хүүхдийн эрүүл мэндийн төвд амаржиж 3 ихэр охидтой болсон. Тус иргэдийн бүртгэлийг дүүргийн Засаг дарга Ж.Алдаржавхлан, хорооны Засаг дарга Л.Баярдалай болон дүүргийн зарим удирдлагууд ёслол төгөлдөр гардуулан өглөө.





**1.10. Мэдээлэл технологийн чиглэлээр:**

Нийслэлийн хуучин 152 хорооноос Баянзүрх дүүргийн 11, Сонгинохайрхан дүүргийн 21 дүгээр хороо нэгдсэн сүлжээнд холбогдоогүй байна. Шинээр байгуулагдсан 19 хорооны 7 хороонд шилэн кабель татагдсан.

Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар тус газрын 10 хороонд тус бүр 7 төрлийн тоног төхөөрөмж шинээр олгохоор болсон бөгөөд одоогийн байдлаар 47195500 /дөчин долоон сая нэг зуун ерэн таван мянга таван зуу/ төгрөгийн үнэ бүхий 3 төрлийн 30 ширхэг тоног төхөөрөмж хүлээн аваад байна.

**1.10.2. Мэдээллийн ил тод байдлыг хангах, сурталчлах чиглэлээр:**

Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг ханган ажиллаж, газрын төсөв санхүү, орлого, зарлагын гүйлгээний мэдээ, мэдээллийг цахим хуудас болон мэдээллийн самбараар дамжуулан олон нийтэд мэдээлсэн. Тайлангийн хугацаанд [www.nubg.ub.gov.mn](http://www.nubg.ub.gov.mn) сайтанд бүртгэлийн хууль тогтоомж, цаг үеийн мэдээ, мэдээллийг 50 удаа иргэдэд ойлгомжтой, хүртээмжтэй байдлаар байршуулан ажилласан. Мөн газар хэлтсүүдийн Facebook-ийн хуудсаар дамжуулан цаг үеийн мэдээ мэдээллийг тогтмол байршуулж байгууллагын үйл ажиллагааг сурталчилсан.

“Дэлхийн Монголчуудын радио MGL FM88.3-ийн “Өдрийн хөтөлбөр”-т улсын бүртгэлийн мэдээ, мэдээллийг хүргэх албан хаагчдын хуваарийг Нийслэлийн улсын бүртгэлийн газрын даргаар батлуулан ажиллаж байна.

д/д	Нэгжийн нэр	Арга хэмжээний нэр	Хугацаа, хамрагдсан
-----	-------------	--------------------	---------------------

			харилцагч	
1	НУБГ	Дэлхийн Монгол MGL FM88.3 радиод байгууллагын ил тод нээлттэй байдлыг ханган, байгууллагын үйл ажиллагааг сурталчилж мэдээлэх, улсын бүртгэлийн үйл ажиллагаанд дагаж мөрдөж байгаа хууль тогтоомж, дүрэм журам, улсын бүртгэлийн үйлчилгээ, болон заавар зөвлөмж, төр засгийн бодлого шийдвэртэй холбогдсон мэдээ, мэдээллийг иргэдэд нээлттэй, шуурхай хүргэх, иргэдийн санал бодлыг сонсох зорилгоор “Дэлхийн Монголчуудын радио MGL FM88.3”-радиотай хамтран “Өдрийн хөтөлбөр”-өөр иргэдэд мэдээлэл хүргэх хуваарийн дагуу хүргэв	23 удаа /Мягмар гариг бүрийн 14.30/	
2		Нийслэл дэх Улсын бүртгэлийн газрын цахим хуудас <a href="http://www.nubg.ub.gov.mn/">www.nubg.ub.gov.mn/</a> -ын “Сонгогчийн боловсрол” булан шинээр нээж, харилцагч иргэдэд Монгол Улсын Их хурлын сонгуулийн тухай хуулиас “сонгогчийн мэдвэл зохих хуулийн заалт”-уудаас хэсэгчлэн орууллаа	8 удаа	
2	Бүх нэгжүүд	FB профайл зургийг "Хотоо соёлтой болгоё" хуудсаар сольсон.	Нийт 112 албан хаагч	
3		"Хотоо соёлтой болгоё" зурагт хуудсыг мэдээллийн самбарт байршуулсан	9 дүүрэг дэх Улсын бүртгэлийн хэлтэс, ННҮТ-ийн мэдээллийн самбарт байршуулсан 100 хувь	
4		Цаг үеийн мэдээ, мэдээлэл үйлчилгээ	Нийт 59 удаа шинэчилж	
5		Ковид -19-с хэрхэн сэргийлэх тухай мэдээлэл		
6		Тоон мэдээ /УБЕГ/	Нийт 29731 харилцагч тус цахим хуудсанд зочилсон байна.	
7		<a href="http://www.burtgel.gov.mn">www.burtgel.gov.mn</a> , <a href="http://nubg.gov.mn">nubg.gov.mn</a> болон Нийслэлийн төрийн захиргааны байгууллагын ер системд тус тус СНЖ-г байршуулав		
8		Олон нийтийн цагдаагийн чиг үүрэг		
9		Ёслолтой бүртгэл	73 хос	157 харилцагч оролцов.

10		262647/ 267013, 77771890 дугаарын утсуудаар харилцагчдад мэдээлэл өгөв.	890 харилцагчид утсаар мэдээлэл өгөв.
		НИЙТ 10 АРГА ХЭМЖЭЭГ 36 УДАА ЗОХИОН БАЙГУУЛАВ.	9914
1	Мэдээлэлийн цаг	Цаг үеийн мэдээлэл, хууль тогтоомж, Удирдах ажилтны сургалтын тухай мэдээлэл	НИЙТ 15 УДААГИЙН АРГА ХЭМЖЭЭ
2		УИХ-ын Сонгуулийн хууль хэрэгжүүлэхтэй холбоотой арга хэмжээ, чиглэл танилцуулав.	
3		ХШГ-ын 8/3377, НУБГ-ын 1/527 тоот чиглэл танилцуулсан	
4		Бүртгэлийн шинэ систем дээр дадлага хийх заавар зөвлөмж өгөв.	
5		Биотерроризмын аюул занал, түүнээс урьдчилан сэргийлэх асуудал зөвлөмж танилцуулав	
6		Эргүүлийн тухай	
			158 ажилтан албан хаагч оролцов.

Нийслэлийн улсын бүртгэлийн газрын албан ёсны вэбсайт болон FB хуудсан дэх харилцагчдад зориулсан мэдээллийн шуурхай, чанартай байдлыг хангах зорилгоор уг үйл явцын зураглал болон нэгжүүдийн хийж гүйцэтгэх ажлыг цаг хугацааны хувьд албажуулж, газрын даргаар батлуулан хэрэгжилтийг ханган ажиллах чиглэлийг нэгжүүдэд хүргүүлэв.

**Улсын бүртгэлийн үйлчилгээнд өгсөн “Харилцагчдын үнэлгээ”-ний систем нэвтрүүлэх ажлын хүрээнд:**

Тайлангийн хугацаанд нийт 1321 харилцагчаас цаасан хэлбэрээр “Бүртгэлийн байгууллагын үйлчилгээ”-нд үнэлгээ авсан бөгөөд тус байгууллагаас авсан үйлчилгээний чанарыг 97,7 хувь гэж харилцагчид дүгнэсэн байна.

**Харилцагчдыг мэдээ, мэдээллээр хангах, эрх зүйн боловсролыг дээшлүүлэх чиглэлээр хийгдсэн ажлууд**

Бүх нийтийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх үндэсний хөтөлбөрийн зорилгын хүрээнд нийт иргэдэд эрх зүйн мэдээ, мэдлэгийг цахим болон цахим бус байдлаар нээлттэй, хүртээмжтэй, энгийн хялбарчилсан хэлбэрээр хүргэхэд зориулж иргэний улсын бүртгэл, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл болон лавлагаа олголтын бүрдүүлбэр, анхаарах асуудал, зөвлөгөө, байршил зэрэг мэдээллийг бэлтгэж, Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн Хууль зүйн сургалт, мэдээлэл, сурталчилгааны төвд хүргүүлж, улмаар тус төвийн эрхлэн хөтөлдөг “эрх зүйн цахим хөтөч” цахим сангийн мэдээлэл түгээхэд бэлтгэл хангав.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэнд улсын бүртгэлийн үйлчилгээг тэгш авах боломжийг бүрдүүлэх зорилгоор хороо бүр ойрын харааны шилийг байрлуулсан.






### **1.11.Бичиг баримтжуулах ажлын хүрээнд**

Монгол Улсын Засгийн газрын 2014 оны “Орон гэргүй, тэнэмэл амьдралтай иргэдийг нийгэмшүүлэх талаар авах арга хэмжээний тухай” 137 дугаар тогтоол Нийслэлийн Засаг даргын 2014 оны А/487 дугаар захирамжийг үндэслэн Нийслэлийн нутаг дэвсгэрт байгаа орон гэргүй, тэнэмэл амьдралтай иргэдийг нийгмийн олон талт үйлчилгээнд хамруулах зорилгоор иргэдийн бичиг баримтын зөрчлийг арилгах ажлын хүрээнд Дүүргүүдийн Засаг даргын Тамгын газар, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зөвлөл, “Зөв амьдрах ухаан” төрийн бус байгууллага, ШШГЕГ-ын харъяа Согтуурах, мансуурах донтой өвчтөнг албадан хөдөлмөр хийлгэх газар зэрэг төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран ажилласан.

- ✓ ШШГЕГ-ын харъяа Согтуурах, мансуурах донтой өвчтөнг албадан хөдөлмөр хийлгэх газрын 12 иргэн
- ✓ Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын 417 дугаар нээлттэй хорих ангид хоригдож буй 17 хоригдолыг биеийн давхцахгүй өгөгдлийн бүртгэлд хамруулан ажилласан.
- ✓ Зорилтод бүлгийн 7 иргэнийг Дэлхийн зөн ОУБ-тай хамтран бичиг баримтжуулсан
- ✓ Гэр бүл, хүүхэд, залуучдын хөгжлийн хэлтсийн “Хүүхэд хамгаалал” 4 дүгээр улирлын нэгдсэн арга хэмжээний үеэр илэрсэн зорилтод бүлгийн 6 хүүхдэд төрсний гэрчилгээ, Огт бичиг баримтгүй 2 хүүхдийн төрсний гэрчилгээг, “Хотын засаглалыг сайжруулах” төслийн хүрээнд 12 иргэнд иргэний үнэмлэх олгож бичиг баримтжуулан хамтран ажилласан.
- ✓ 401 дүгээр хаалттай хорих ангид ял эдэлж буй иргэний шинэчилсэн бүртгэлийг Хорих ангийн нэгдсэн эмнэлэгт очиж гар хурууний хээ, зургийг авч шинэчилсэн бүртгэлийг авч бичиг баримтжуулсан.



- ✓ Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Нийгмийн халамжийн тухай хуулийн 23 дугаар зүйл, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2015 оны 187 дугаар тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2016 оны А/39 дүгээр захирамжийн хүрээнд: “Гэртээ харих зам” дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх 2020 оны үйл ажиллгааны төлөвлөгөөний Иргэдийг бичиг баримтжуулах ажилд хамтран ажиллах ажлын хүрээнд Хан-Уул дүүргийн 5 дугаар хороонд өрх толгойлон амьдардаг зорилтот бүлгийн иргэн Б.Одончимэг нь 6 хүүхэдтэй, 2019 оны 08 дугаар сарын 17-ны өдөр гэр нь шатаж, эд хогшил, бичиг баримтгүй болсон тул Хан-Уул дүүргийн гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн хэлтэстэй хамтран Нийслэлийн онцгой байдлын газрын гал түймэр гарсан тухай актыг үндэслэн доорхи иргэдийг торгуулиас чөлөөлөн бичиг баримтжуулав.
- ✓ Хан-Уул дүүргийн 6 дугаар хороонд амьдардаг Зорилтот бүлгийн 1 иргэнийг Хорооны засаг даргатай, 14 дүгээр хорооны 1 иргэнийг “Өсөх өлзийт” хадгаламж зээлийн хоршоотой тус тус хамтран бичиг баримтжуулав.
- ✓ Сонгинохайрхан дүүргийн улсын бүртгэлийн хэлтэс нь Сонгинохайрхан дүүргийн Засаг даргын 2020 оны 5 дугаар сарын 19-ний өдрийн А/231, 6 дугаар сарын 15-ний өдрийн А/283 тоот захирамжаар Иргэдэд үзүүлэх төрийн үйлчилгээг чирэгдэлгүй түргэн шуурхай хүргэх зорилгоор иргэдийг бичиг баримтжуулах аяныг зохион байгуулахаар болсон. Уг ажлын хүрээнд 2201 иргэнд иргэний үнэмлэх үнэ төлбөргүй олгох ажлыг зохион байгуулж, тус хэлтсийн иргэний бүртгэлийн тасгийн улсын бүртгэгч нар Дүүргийн Засаг даргын Тамгын газраас ирүүлсэн иргэдийн нэрсийг жагсаалтаар авч, бүртгэлийг хөтөлж, иргэдэд иргэний үнэмлэхийг олгох ажлыг хийж гүйцэтгэсэн.

Тайлангийн хугацаанд нийт 2266 иргэний бичиг баримтжуулан ажиллалаа.

### **1.13. Сонгуулийн ажлын хүрээнд:**

Монгол Улсын Их Хурлын 2020 оны ээлжит сонгуулийг зохион байгуулах бэлтгэл ажлын хүрээнд Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль, холбогдох бусад хууль тогтоомжид заасан улсын бүртгэлийн байгууллагын чиг үүргийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах үүрэг бүхий ажлын хэсгийг Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2020 оны А/05 дугаар тушаалаар баталсан.

Дээрх ажлын хэсгийн 2020 оны 01 дүгээр сарын 13-ны өдрийн хурлаар “Монгол Улсын Их Хурлын 2020 оны ээлжит сонгуулийн хуулийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны 60 заалт бүхий төлөвлөө”-ний төслийг танилцуулсан. Уг төлөвлөгөөнд НУБГазар нь дүүрэг дэх УБХ-үүдээс санал авч нэгтгэн, ажлын хэсэгт хүргүүлсэн. Мөн Сонгогчдын нэрийн жагсаалт үйлдэх, нягтлан шалгах, танилцуулах, сонгогч шилжих журмын төсөлд саналыг Ажлын хэсэгт хүргүүлсэн.

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1, 25.2 дахь заалт, Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2020 оны 01 дүгээр сарын 27-ны өдрийн “Иргэний шилжилт хөдөлгөөнийг зогсоох тухай” А/126 дугаар тушаалын хэрэгжилтийг хангах зорилгоор тус газраас дараах арга хэмжээг авч ажиллалаа. Үүнд:

1. Бүртгэсэн төлөвтэй шилжилт хөдөлгөөний бүртгэлийг иргэний улсын бүртгэлийн мэдээллийн санд тухай бүрт баталгаажуулсан эсэхийг сайтар нягтлан шалгасан. /2020

оны 01 дүгээр сарын 01-нээс 1 дүгээр сарын 31-ний байдлаар 34243 бүртгэлийг бүрэн гүйцэд баталгаажуулсан байна/

2. Иргэний улсын ахлах бүртгэгч бүртгэлийн дэвтэрт “шилжилт хөдөлгөөн зогсоосон тухай” тэмдэглэгээг 1 дүгээр сарын 31-ний өдрөөр тасалбар болгон нийт 357 бүртгэлийн дэвтрийг хүлээн авсан байна.

3. Хорооны улсын бүртгэгч нар 2020 оны 01 дүгээр сарын 01-нээс 1 дүгээр сарын 31-ний хүртэл бүртгэл хөтөлсөн 34243 ш ИУБ-22 маягтыг жагсаалт үйлдэн, дагалдах хуудсын хамт хэлтсийн архивчид хүлээлгэн өгсөн байна.

4. Хорооны улсын бүртгэгч нараас 2020 оны 01 дүгээр сарын 31-ний өдрөөр тасалбар болгон нийт 357 ш бүртгэлийн дэвтэр, үлдэгдэл 14701 ш ИУБ-22 маягтыг тэмдэглэл үйлдэн лацдаж, дүүргийн улсын бүртгэлийн хэлтэст хадгалах ажлыг хийж гүйцэтгэсэн.

Улсын бүртгэлийн ерөнхий газраас сонгуулийн тухай хуулийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд улсын бүртгэлийн цахим мэдээллийн сангаас тухайн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжид байнга оршин суугаа газрын хаягийн бүртгэлтэй сонгогчийн тоог ирүүлснийг тус газрын 2020 оны 02 дугаар сарын 07-ны өдрийн 1/239 дугаартай албан бичгээр нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчид, Нийслэлийн Засаг дарга болон нийслэлийн Засаг даргын Тамгын газар тус тус хүргүүлсэн.

Мөн Монгол Улсын Их Хурлын Сонгуулийн тухай хуулийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны ерөнхий төлөвлөгөөнийн 20-д заасны дагуу нийслэлийн хэмжээнд “Сонгуулийн 451 хэсэг байгуулж, хэсгийн нутаг дэвсгэр, төвийг зарласан тухай” дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн тогтоолыг дүүрэг дэх Улсын бүртгэлийн хэлтсүүд хүлээн авч, эх хувийг Иргэний Улсын бүртгэлийн газарт албан бичгээр хуулийн хугацаанд хүргүүлж ажилласан.

Нийслэлийн хэмжээнд 2020 оны 04 дугаар сарын 28-ны байдлаар /election.gasr.mn/ цахим санд 451 хэсгийн **993696** сонгуулийн эрх бүхий иргэнд хэсгийг оноосон. Мөн сонгуулийн хэсэгт байнга оршин суух хаягийн бүртгэлтэй сонгуулийн эрх бүхий иргэдийг хорооны улсын бүртгэгч нар нягтлан шалгаж, хэсэг оноогдоогүй үлдсэн **631** сонгуулийн эрх бүхий иргэнд хэсэг оноох ажлыг хийж гүйцэтгэсэн.

Цахим хуудсанд байршуулсан сонгогчийн нэрийн жагсаалт дахь өөрт холбогдох мэдээлэлтэй танилцаж баталгаажуулах, гомдол гарсан тохиолдолд бүртгэл хөтлөж, холбогдох асуудлыг тухай бүр шийдвэрлэх талаар улсын ахлах бүртгэгч нарт чиглэл өгч ажилласан.

Нийслэлийн хэмжээнд сонгогчийн мэдээлэл зөрүүтэй гэх 4 удаагийн жагсаалтаар 261 иргэний жагсаалтыг Мэдээлэл технологийн газраас ирүүлснийг дүүрэг дэх Улсын бүртгэлийн хэлтсийн дарга нарт НУБГ-ын шуурхай хурлаар дүүрэг тус бүрээр танилцуулж, холбогдох зөрчлийг арилгах талаар газрын дарга үүрэг өгч ажилласан. Дээрх 261 иргэний жагсаалтыг тухай бүр 9 дүүргийн улсын ахлах бүртгэгч нарт хүргүүлж, зөрчлийг арилгасан талаарх тайлбарыг “Сонгууль-2020” цахим хаягаар хүргүүлж ажиллаж байна.

Монгол Улсын Их хурлын сонгуулийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.9-т заасан “Улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага энэ хуулийн 20.4-т заасны дагуу цахим хуудсанд байршуулсан сонгогчдын нэрийн жагсаалтад дараах өөрчлөлтийг тусган уг жагсаалтыг цаасан болон цахим хэлбэрээр үйлдэж, цаасан хэлбэрээр үйлдсэн сонгогчдын нэрийн жагсаалтыг санал авах өдрөөс 25-аас доошгүй хоногийн өмнө

улсын бүртгэлийн орон нутаг дахь газар, хэлтсээр дамжуулан хэсгийн хороонд хүргүүлнэ” гэж заасны дагуу нийслэлийн хэмжээнд 2020 оны 05 дугаар сарын 27-ны өдөр улсын ахлах бүртгэгч болон улсын бүртгэгч нар нь олгогдсон эрхийн дагуу цахим санд нэвтэрч, сонгогчдын нэрийн жагсаалтыг Мэдээлэл технологийн газраас ирүүлсэн зөвлөмжийн дагуу хэсэг тус бүрээр 3 хувь хэвлэх үйл ажиллагааг эхлүүлсэн. Сонгогчдын нэрийн жагсаалт хэвлэх үйл ажиллагаанд дүүрэг дэх Улсын бүртгэлийн хэлтсийн дарга, хяналтын улсын байцаагч, тасгийн дарга бөгөөд улсын ахлах бүртгэгч, улсын бүртгэгч, мэдээлэл технологийн ажилтнаас бүрдсэн нийт 167 ажилтан албан хаагчийн бүрэлдэхүүнтэй баг хяналт тавин ажилласан байна.

Нийслэлийн хэмжээнд 2020 оны 05 дугаар сарын 27-ны өдөр /election.gasr.mn/ цахим сангаас сонгуулийн 451 хэсгийн сонгогчдын нэрийн жагсаалтыг 3 хувь хэвлэсэн бөгөөд үүнээс үндсэн сонгогч 896767, “Түр хасав” тэмдэглэгээтэй 95723 сонгогч бүртгэлтэй байсныг хэсэг тус бүрээр тэмдэглэл үйлдэж ажилласан.

Сонгогчдын нэрийн жагсаалт хэвлэсэн тухай дүүрэг тус бүрээр харуулбал:

д/д	Дүүрэг	Сонгуулийн хэсгийн тоо	СНЖ-д байгаа сонгогчдын тоо	Үндсэн сонгогч	“Түр хасав” тэмдэглэгээ тавигдсан сонгогч	Хэвлэсэн хуудасны тоо
1	Багануур	11	19583	18367	1216	489
2	Багахангай	2	2878	2692	186	71
3	Баянгол	77	153643	135721	17922	5640
4	Баянзүрх	100	245747	222172	23575	8558
5	Налайх	13	25163	23479	1684	605
6	Сонгинохайрхан	102	212179	195768	16411	8145
7	Сүхбаатар	42	98281	86872	11409	3200
8	Хан-Уул	60	127744	114968	12776	4240
9	Чингэлтэй	44	107272	96728	10544	3323
	<b>Дүн</b>	<b>451</b>	<b>992490</b>	<b>896767</b>	<b>95723</b>	<b>34271</b>

Мөн хэвлэгдсэн сонгогчдын нэрийн жагсаалтыг улсын бүртгэгч нар нүүрлэх, нуруулдах хавтасласны дараа сонгогчдын нэрийн жагсаалтын хуудасны дугаар болон тухайн хуудасны эхэлсэн болон дууссан дэс дугаарыг хуудас тус бүрээр нягтлан шалгаж, 3 хувь стандартын дагуу хэвлэгдсэн /нэрийн жагсаалт болон жагсаалтад байх тэмдэглэгээнүүд бүрэн гүйцэд тод

хэвлэгдсэн/ эсэхийг хувь тус бүрээр тус тус нягтлан шалгаж, хяналт тавьж ажилласан бөгөөд сонгогчдын нэрийн жагсаалт хэвлэх хугацаанд ямар нэгэн зөрчил гараагүй болно.

Сонгогчдын нэрийн жагсаалтыг тестлэх явцад стандарт хэмжээ алдагдснаас бичвэр нуруулдах хэсэгт орсон болон хуудас дугааргүй гарсан, СНЖ-д тэмдэглэгдсэн тэмдэглэгээнүүд огт гараагүй болон дутуу гарсан, цаас давхар татагдаж нэр 2 цаас дээр хуваагдаж гарсан зэрэг техникийн алдаанаас шалтгаалсан болон принтерийн хор бүдэг гарснаас шаардлага хангахгүй хэвлэгдсэн сонгогчдын нэрийн жагсаалтын хуудсыг хэсгийн болон хуудасны дугаараар бүртгэн тоолж, акт үйлдэн хяналтын улсын байцаагч, улсын ахлах бүртгэгч, Нийслэл дэх Улсын бүртгэлийн газраас хяналт тавьж оролцсон ажилтан нарын хяналт дор нийт 7560 хуудас цаасыг цаас хэрчигч машин ашиглан устгалд оруулсан байна.

Мөн Сонгуулийн хэсгийн хороонд сонгогчдын нэрийн жагсаалтыг нийслэлийн сонгуулийн 451 хэсэгт сонгогчдын нэрийн жагсаалтын 1 хувийг цаасан хэлбэрээр хүлээлцсэн бөгөөд үүнээс үндсэн сонгогч 896767, “Түр хасав” тэмдэглэгээтэй 95723 сонгогч бүртгэгдснийг хэсэг тус бүрээр сонгогчдын нэрийн жагсаалт хүлээлцэх актад тэмдэглэл үйлдэж, 2020 оны 05 дугаар сарын 29-ний өдөр хуульд заасны дагуу хүлээлгэн өгсөн байна.

**Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны ээлжит сонгуулийг зохион байгуулах бэлтгэл ажлын талаар:**

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны ээлжит сонгуулийн бэлтгэл ажлын хүрээнд Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, холбогдох бусад хууль тогтоомжид заасан улсын бүртгэлийн байгууллагын чиг үүргийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах үүрэг бүхий ажлын хэсгийг Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2020 оны А/594 дугаар тушаалаар баталсан.

Дээрх ажлын хэсгийн 2020 оны 06 дугаар сарын 02-ны өдрийн хурлаар “Монгол Улсын Их Хурлын 2020 оны ээлжит сонгуулийн хуулийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны 73 заалт бүхий төлөвлөө”-ний төслийг танилцуулсан. Уг төлөвлөгөөнд НУБГазар нь дүүрэг дэх УБХ-үүдээс санал авч нэгтгэн, ажлын хэсэгт хүргүүлсэн. Мөн Сонгогчдын нэрийн жагсаалт үйлдэх, нягтлан шалгах, танилцуулах, сонгогч шилжих журмын төсөлд саналыг Ажлын хэсэгт хүргүүлсэн.

Монгол Улсын Их Хурлын чуулганы 2020 оны 04 дүгээр сарын 16-ны өдрийн 23 дугаар тогтоолоор Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны ээлжит сонгуулийг 2020 оны 04 дүгээр сарын 30-ны өдрөөс товлон зарлаж, сонгуулийн санал авах өдрийг 2020 оны 10 дугаар сарын 15-ны өдөр байхаар тогтоосон.

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.2-т сонгогчдын санал авч, тоолох зорилгоор сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчид сонгуулийн хэсэг байгуулахдаа улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын саналыг харгалзан иргэний улсын бүртгэлийн цахим мэдээллийн сан дахь тухайн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжид байнга оршин суугаа газрын хаягийн бүртгэлтэй сонгогчийн тоонд үндэслэхээр заасан.

Тус газар нь 2020 оны 05 дугаар сарын 07-ны өдрийн 1/741 дугаар албан бичгээр бүртгэлийн цахим мэдээллийн сангаас тухайн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжид



байнга оршин суугаа газрын хаягийн бүртгэлтэй сонгогчийн тоог 2020 оны 05 дугаар сарын 07-ны өдрийн 11.00 цагийн байдлаар гаргаж, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд хүргүүлсэн.

Сонгуулийн хэсэг байгуулсан тухай иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн тогтоолыг хууль тогтоомжид нийцүүлж, нэг хэсэгт байх сонгогчдын тоог нягтлан, сонгуулийн хэсэгт хамаарах нутаг дэвсгэр буюу байр, гудамж бүрэн орсон эсэхийг сайтар нягтлан шалгаж тогтоолын эх хувийг Иргэний улсын бүртгэлийн газарт тус тус албан бичгээр хүргүүлж ажилласан. Мөн Тойрог, хэсгийн нутаг дэвсгэр, санал авах байрны мэдээллийг иргэний улсын бүртгэлийн мэдээллийн цахим санд оруулах албан хаагчдад эрх нээх албан бичгийг Иргэний улсын бүртгэлийн газарт хүргүүлсэн байна.

#### **1.14. Хороо хуваагдахтай холбоотойгоор зохион байгуулсан ажил:**

Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2019 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн “Хороодын бүтэц, зохион байгуулалтад өөрчлөлт оруулах тухай” 25/21 дүгээр тогтоолоор нийслэлийн Налайх дүүрэгт 1, Хан-Уул дүүрэгт-5, Сонгинохайрхан дүүрэгт 11 хороо, 2019 оны 11 дүгээр сарын 22-ны өдрийн “Хороодын бүтэц, зохион байгуулалтад өөрчлөлт оруулах тухай” 8/28 тоот тогтоолоор Баянгол дүүрэгт 2 хороог шинээр байгуулахаар шийдвэрлэсэн.

Тус шийдвэрийн дагуу Налайх дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2019 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн “Дүүргийн хороодын хилийн заагийг шинэчлэн батлах тухай” 35 дугаар, Сонгинохайрхан дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2019 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн “Шинэ болон хилийн цэсэд өөрчлөлт орсон хороодод гудамжны нэр, дугаар олгох тухай” А/69 дугаар, Хан-Уул дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2019 оны 09 дүгээр сарын 9-ний өдрийн “Зарим хороодын нутаг дэвсгэрийн хилийн цэсийг шинэчлэн батлах тухай” 35 дугаар, Баянгол дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2019 оны 11 дүгээр сарын 22-ны өдрийн “Хороодын бүтэц, зохион байгуулалтад өөрчлөлт оруулах тухай” 8/28 дугаар тогтоол тус тус гарч нийслэлийн хэмжээнд 19 хороог шинээр байгуулсан.

Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн тогтоолыг үндэслэн “Бүртгэлд нэмэлт өөрчлөлт оруулах тухай” Хан-Уул дүүргийн Улсын бүртгэлийн хэлтсийн хяналтын улсын байцаагчийн 2019 оны 4705, Сонгинохайрхан дүүргийн Улсын бүртгэлийн хэлтсийн хяналтын улсын байцаагчийн 2019 оны 4702, Налайх дүүргийн Улсын бүртгэлийн хэлтсийн хяналтын улсын байцаагчийн 2019 оны 50/4704, Баянгол дүүргийн Улсын бүртгэлийн хэлтсийн хяналтын улсын байцаагчийн 2019 оны 4703 дүгээр дүгнэлт тус тус гарсан.

Ажлын хэсгээс өгсөн үүрэг чиглэлийн хүрээнд нийслэлийн хэмжээнд шинээр зохион байгуулагдсан 19 хороонд байнга оршин суух хаягийн бүртгэлтэй 145573 иргэний хаягийн бүртгэлд өөрчлөлт орсон.

Улсын бүртгэлийн ерөнхий газрын дэд даргаар ахлуулсан ажлын хэсэг нь 2020 оны 01 дүгээр сарын 23-ны өдөр Нийслэлийн улсын бүртгэлийн газрын дарга, Бүртгэлийн хэлтсийн улсын ахлах бүртгэгч, дүүргийн Улсын бүртгэлийн хэлтсийн дарга, иргэн, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тасгийн улсын ахлах бүртгэгч нарыг хамруулсан хурлыг зохион байгуулж, ажлын хэсгийн даргаас шинээр хаяг нь өөрчлөгдсөн, иргэний улсын бүртгэлийн



мэдээллийн санд бүртгэгдсэн иргэдийн иргэний үнэмлэх солих, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн гэрчилгээ солих, хуулийн этгээдийн улсын бүртгэлд нэмэлт өөрчлөлтийг хэрхэн хийх талаар бүртгэл тус бүрээр үүрэг чиглэлийг өгч ажилласан. Мөн ажлын хэсгээс ирүүлсэн чиглэлийг Нийслэлийн үйлчилгээний нэгдсэн төвийн ахлахуудад хүргүүлж, мэдээллийг нэг бүрчлэн өгч, иргэний улсын бүртгэлийн мэдээллийн санд бүртгэгдсэн иргэдийн иргэний үнэмлэх солих, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн гэрчилгээ солих, хуулийн этгээдийн улсын бүртгэлд нэмэлт өөрчлөлтийг бүртгэсэн тухай тоон мэдээ авах хүснэгтийг боловсруулж дүүргийн Улсын бүртгэлийн хэлтсүүд болон Нийслэлийн үйлчилгээний нэгдсэн төвүүдэд хүргүүлээд байна. Нийслэлийн хэмжээнд нийт 16514 иргэнд иргэний үнэмлэхийг сольж олгосон байна

### **1.15. Ковид цар тахлын хүрээнд хийж хэрэгжүүлсэн ажлууд**

Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2020.03.13-ны өдрийн “Ажлын тусгай горимд шилжүүлэх тухай” А/259 дүгээр тушаалын дагуу Газар, дүүргийн Улсын бүртгэлийн хэлтсийн албан хаагчид 3 дугаар сарын 16-ны өдрөөс эхлэн 09.00-15.00 хүртэл, Нийслэлийн үйлчилгээний нэгдсэн төв /Мишээл, Дүнжингарав, Оргил, Драгон/ дэх Бүртгэлийн хэлтсийн албан хаагчид Нийслэлийн Засаг даргын 2020 оны А/369 дүгээр захирамжийн дагуу 3 дугаар сарын 19-ний өдрөөс эхлэн 30-ны өдөр хүртэл 10.00-16.00 цаг хүртэл ажлын цагийг богиносгон, Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2020 оны “Ажлын тусгай горимд шилжүүлэх тухай” А/419 дүгээр тушаалын дагуу газар, дүүргийн Улсын бүртгэлийн хэлтсийн албан хаагчид 4 дүгээр сарын 30-ны өдрийг дуустал 09.00-15.00 цагийн хооронд иргэн хуулийн этгээдэд улсын бүртгэлийн үйлчилгээ үзүүлж, албан хаагчид 9.00-17.00 цаг хүртэл ажилласан. Нийслэлийн үйлчилгээний нэгдсэн төв /Мишээл, Дүнжингарав, Оргил, Драгон/ дэх Бүртгэлийн хэлтсийн албан хаагчид Нийслэлийн Засаг даргын ажлын цаг богиносгох захирамж гараагүйгээс шалтгаалан 4 дүгээр сарын 30-ны өдрийг дуустал энгийн цагийн хуваариар буюу 9.00-18.00 цаг хүртэл, Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2020.04.30-ны өдрийн “Ажлын тусгай горимд шилжүүлсэн хугацааг сунгах тухай” А/554 дүгээр тушаалын дагуу газар, дүүргийн Улсын бүртгэлийн хэлтсийн албан хаагчид 5 дугаар сарын 31-ний өдрийг дуустал 09.00-15.00 цагийн хооронд иргэн хуулийн этгээдэд улсын бүртгэлийн үйлчилгээ үзүүлж, албан хаагчид 9.00-17.00 цаг хүртэл ажилласан. Нийслэлийн үйлчилгээний нэгдсэн төв /Мишээл, Дүнжингарав, Оргил, Драгон/ дэх Бүртгэлийн хэлтсийн албан хаагчид Нийслэлийн Засаг даргын ажлын цаг богиносгох захирамж гараагүйгээс шалтгаалан 5 дугаар сарын 31-ний өдрийг дуустал энгийн цагийн хуваариар буюу 9.00-18.00 цаг хүртэл ажиллаж иргэдэд үйлчилсэн.

Нийт албан хаагчид “Ажлын тусгай горимд шилжих үеийн удирдамж”-ыг өдөр тутмын үйл ажиллагаандаа мөрдөн ажилласан болно.

“Онцгой эрхтэй хариуцлагатай зохицуулагч”-ийн үүргийг 2020 оны 1 дүгээр сарын 19-нөөс 20-ны өдрийн 09 цаг хүртэл 24 цагийн хугацаанд гүйцэтгэж, Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын байранд ажилласан.

#### **Ажлын тусгай горимын үед дараах арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэв.Үүнд:**

➤ Эрүүл мэндийн зөвлөгөө, халдвараас урьдчилан сэргийлэх сэрэмжлүүлэг, зөвлөмж бүхий сурталчилгааны зурагт хуудсын ажлын байр, үйлчилгээний танхим, үйлчилгээ үзүүлж буй цонхонд байршуулах ажлын хүрээнд томуу, томуу төст өвчний тархалт, урьдчилан сэргийлэх, эмнэлгийн тусламж үйлчилгээний талаарх мэдээллийг иргэд, албан хаагчдад

газрын цахим хуудас, хэлтэс нэгжийн үйлчилгээний зааланд байршуулан мэдээлэл хүргэхийн зэрэгцээ цахимаар үйлчилгээ авах зааврыг газрын цахим хуудсанд дахин байршуулан иргэдийг зарим төрлийн бүртгэлийн үйлчилгээг гэрээсээ авахыг уриалсан.

➤ Албан хаагч болон үйлчлүүлэгчдийг гар халдваргүйжүүлэх нөхцлөөр хангах ажлын хүрээнд шаардагдах ариутгалын стирт, клорценпт, жавелион, гипохлорид натрийн уусмалаар халдваргүйжүүлэлтийг өдөрт 3 удаа хийж, гар ариутгагчийг 9 дүүрэг, газрын байранд байршуулан албан хаагчид, үйлчлүүлэгчдийг гараа халдваргүйжүүлэх болон иргэдийг ариун цэврийн өрөөгөөр үнэ төлбөргүй үйлчлүүлэх нөхцлөөр хангасан.

➤ Албан хаагчдыг халдвараас урьдчилан сэргийлэх үүднээс биеийн халууныг өглөө, өдөр, орой гэсэн давтамжтай хэмжих, амны хаалт, ариутгалын материалаар тогтмол хангах ажлын хүрээнд Урьдчилан сэргийлэлт, ариутгал, халдваргүйжүүлэлтэд шаардагдах зардлыг байгууллагын төсвөөс гаргаж, 2020 оны 3 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 4170 амны хаалт, гар ариутгагч санитол 390 ширхэг, ариутгалын спирт 15 литр, хуруу уншигч төхөөрөмж цэвэрлэгч 112, винт 40, тараах материал 104, Улсын бүртгэлийн ерөнхий газраас 4579 амны хаалт, гар ариутгагч санитол 236 ширхэг, ариутгалын спирт 80 литр, хуруу уншигч төхөөрөмж цэвэрлэгч 120, винт 13, ариутгалын хөвөн 90, малгай 2700, бээлий 2075 ширхэг, хамгаалалтын маск 7, халуун хэмжигч 7, гарын саван 6 ширхгийг тус тус нийт албан хаагчдад тараан олгосон. 4 дүгээр сарын 7-нд Улсын бүртгэлийн ерөнхий газраас малгай 1350, бээлий 1350, санитол 60, гарын саван 6, амны хаалт 780 ширхгийг авч албан хаагчдад олгосон. 5 дугаар сард Архивын хэлтсийн албан хаагчид өөрсдийн нөөц бололцоогоор 150 ширхэг нэг удаагийн амны хаалт худалдан авч төвийн 6 дүүргийн архивчдад хүргүүлсэн, мөн тус газраас 1300 ширхэг амны хаалт худалдан авч албан хаагчдад тараан өгч, халдвараас урьдчилан сэргийлэх арга хэмжээг тогтмол авч, гар барьж мэндчилэхгүй байх, гараа тогтмол угаах, гар ариутгагч хэрэглэхийг үүрэг болгосон. Мөн албан хаагчдын халууныг халуун хэмжигч багажаар өдрийн 3 удаа үзсэн. Биеийн халуун өндөр албан хаагч байгаагүй.

➤ Ажлын байр, өрөө тасалгаанд агаар сэлгэлтийг тогтмол хийж, эд зүйлсээ ариутгаж цэвэрлэх ажлын хүрээнд ажлын байр, өрөө тасалгаанд агаар сэлгэлтийг өрөө тасалгаанд тогтмол хийж, эд зүйлсээ ариутган цэвэрлэсэн.

➤ Албан хаагч, үйлчлүүлэгчдэд эрүүл мэндийн байгууллага, онцгой комиссын шийдвэрийг биелүүлэх шаардлага, зөвлөмжийг тогтмол тавьж ажиллах үүрэг бүхий хариуцлагатай жижүүрийг үйлчилгээний байранд хуваарийн дагуу ажиллуулах арга хэмжээ авах ажлын хүрээнд үйлчлүүлэхээр ирж буй иргэдэд амны хаалт зүүх шаардлага тавьж, амны хаалтгүй иргэдэд үйлчлэхгүй болохыг анхааруулж, хэрэгжүүлж ажилласан. Үйлчилгээ үзүүлж буй нэгжүүд жижүүрийн хуваарь гарган ажиллуулсан.

➤ Тухайн нэгжид халдварт өвчний сэжиг илэрсэн тохиолдолд тухайн орон нутгийн онцгой комисст мэдэгдсэний үндсэн дээр өгсөн чиглэл, зааврын дагуу ажлын байрыг бүрэн эсвэл хэсэгчлэн хаах, үйлчилгээг зогсоох арга хэмжээг яаралтай авч, дээд шатны байгууллагад энэ тухай мэдэгдэх заалтын хүрээнд тухайн нэгжид халдварт өвчний сэжиг илэрсэн тохиолдолд авах арга хэмжээний бэлтгэл ажлыг зааврын дагуу хангасан бөгөөд тайлант хугацаанд халдварт өвчний сэжиг илрээгүй.

➤ Харьяа нэгж тасаг болон үйлчилгээний ажилтнууд ажлын байрны халдваргүйжүүлэлт, цэвэрлэгээг тогтмол хийж байгаа эсэхэд хяналт тавих ажлын хүрээнд үйлчилгээний ажилтнууд ажлын байрны халдваргүйжүүлэлт, цэвэрлэгээг тогтмол хийж байна. Хяналтыг тухайн нэгжийн ахлах ажилтнууд тавьж байна.


➤ Эрүүл мэндийн яам, Улсын болон орон нутгийн онцгой комиссын шийдвэр, удирдамжийг биелүүлэх хүрээнд Улс, нийслэлийн онцгой комисс, Эрүүл мэндийн яамны /www.mohs.mn/ цахим хуудас, эрүүл мэндийн байгууллагуудын зөвлөмж, шийдвэрийг тухай бүр газрын цахим хуудсанд байршуулан иргэд, албан хаагчдыг мэдээллээр шуурхай ханган ажиллаж байна. Нийслэлийн онцгой комиссын өгсөн үүргийн дагуу өндөржүүлсэн бэлэн байдал зарласан хугацаанаас буюу 2020 оны 02 дугаар сарын 21-ний өдрөөс 6 дугаар сарын 5-ны өдрийг хүртэл тус газраас давхардсан тоогоор 2850 албан хаагч эргүүлийн үүргийг гүйцэтгэж 46158 иргэнд зөвлөмж өгч, 31215 тараах материалыг тарааж, 12152 аж ахуй нэгж байгууллагаар орж, ариутгал цэвэрлэгээ, халдваргүйжүүлэлтэд хяналт тавьж, 5214 зөрчил гаргасан /амны хаалтгүй, ил задгай шүлсээ хаясан/ иргэнд анхааруулга, сануулгыг өгч, үүрэг хэрэгжүүлсэн байна. 5 дугаар сард 2 албан хаагч Гүнтийн шалган нэвтрүүлэх постонд 24 цагаар 4 удаа жижүүрлэн ажилласан. “Цэвэрхэн хотын төлөө” аянд нэгдэж 2 удаа бүх нийтийн цэвэрлэгээнд 89 албан хаагч оролцсон. Монгол Улсын Онцгой комиссоос зарласан “Амны хаалтаа зүүцгээе” аяныг амжилттай хэрэгжүүлж тайланг Улсын бүртгэлийн ерөнхий газар, Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт тус тус хүргүүлсэн.

Үйлчилгээний танхимд зай барих сануулгыг шалан дээр байрлуулсан.

2020 оны 05 дугаар сарын 06-08-нд Улс, нийслэлийн Онцгой комиссын шийдвэрээр “Корона вирусын халдвар /КОВИД-19 /-т цар тахлын үеийн харилцан ажиллагаа, хариу арга хэмжээ” сэдэвт дадлага сургуульд Чингэлтэй дүүргийн улсын бүртгэлийн хэлтэс идэвхитэй оролцлоо.



Монгол Улсын түүхэнд анх удаа зохион байгуулагдсан Ковид19 цар тахалын халдварын үеийн хамтын ажиллагаа, хариу арга хэмжээ сэдэвт дадлага сургуулилтад тус хэлтсийн хамт олон идэвхитэй оролцож шуурхай штаб-д 1-19 дүгээр хорооны нийт байр, гудамж тоотын нэгдсэн судалгаа, тус дүүрэгт амьдарч байгаа 14 улсын 289 иргэний дэлгэрэнгүй судалгааг гаргаж өгч, 3 удаагийн цагийн байдлаар ирсэн 198 иргэний мэдээллийг шүүж өгч ажилласан.



### **1.16. Бусад ажил:**

2019-09-30-ны өдрийн Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх тухай А/1016 Нийслэлийн агаарын чанарыг сайжруулах 2, 3 дугаар бүсийн айл өрхүүдийн сайжруулсан шахмал түлшний хуваарилалтыг жигд хүртээмжтэй хангах, хэрэглээнд хяналт тавих зорилгоор сайн картыг иргэдэд бүрэн хүргэх, мэдээллийн сан үүсгэж, цахим бүртгэл хөтлөх арга хэмжээг зохион байгуулах ажлын хүрээнд Нийслэлийн агаарын чанарыг сайжруулах 2, 3 дугаар бүсийн айл өрхүүдийн сайжруулсан шахмал түлшний хуваарилалтыг жигд хүртээмжтэй хангах, хэрэглээнд хяналт тавих зорилгоор сайн картыг иргэдэд бүрэн хүргэх, мэдээллийн сан үүсгэж, цахим бүртгэл хөтлөх арга хэмжээний хүрээнд Нийслэлийн Мэдээллийн технологийн газартай хамтран ажиллаж иргэдийн мэдээллийг нийлүүлэх, тулгах ажлыг хийж гүйцэтгэсэн.

Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэнтэй холбогдуулан захирамжаар өгөгдсөн үүрэг, даалгаврын биелэлтийг 24 цаг тутамд гаргаж Улаанбаатар хотын Шуурхай удирдлага, зохицуулалтын төв /ОНӨААТҮГ/-д хүргүүлэхийг нийслэлийн нутгийн захиргааны нийт байгууллагуудад, ирүүлсэн тайлан мэдээг нэгтгэж 7 хоног тутам Нийслэлийн Онцгой комисст танилцуулж байх чиг үүргийн хүрээнд өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэнтэй холбогдуулан сайжруулсан түлшний татан авалт, түгээлт, борлуултын мэдээг нэгтгэн гаргаж 7 хоног бүр тайлагнаж байна. Мөн тайлангийн хугацаанд 2 удаа нийслэлийн Онцгой комиссын жижүүрээр, дүүргийн Улсын бүртгэлийн хэлтсийн дарга нар дүүргийн Онцгой комиссын жижүүрээр сар бүр ажиллаж нийт газар хэлтсээс тайлангийн хугацаанд 32 удаа жижүүрийн ажлыг хийж гүйцэтгэн, нийслэл Онцгой комисст мэдээллэж ажилласан.



## Сайн үйлсийн аян зохион байгуулсан талаар:

Хүүхдийн тэмүүлэл аянд Чингэлтэй дүүргийн улсын бүртгэлийн хэлтсийн нийт албан хаагчид 3000 төгрөг хандивлалаа. Нийт 75000 төгрөг хүлээлгэн өгсөн.

Нийслэлийн Засаг даргын А/268 тоот захирамж гарсаны дагуу 12 хүртлэх насны хүүхэдтэй албан хаагчдын дэлгэрэнгүй судалгааг гаргаж ажилласан. "Сэтгэлийн тус багадахгүй сайн дурын аян"-д тус хэлтэс идэвхитэй оролцсон.



ХЯНАСАН:  
ЗАХИРГААНЫ ХЭЛТСИЙН ДАРГЫН  
АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН  
ГҮЙЦЭТГЭГЧ

О.БАТТӨМӨР

ТАЙЛАН НЭГТГЭСЭН:  
МЭРГЭЖИЛТЭН:

Ш.САРАНГЭРЭЛ